



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: “ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ,
АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

АУДИТЫН КОД: АГГ-2022/20-ШТА-ГА

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД ЗОХИХ ҮР
ДҮНГЭЭ ӨГЧ 14880 АЖЛЫН БАЙР БИЙ БОЛСОН БАЙНА**

Баян-Өлгий аймаг 2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 цахим хуудас: Khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Жөнисбек
Утас: 70422930 цахим хуудас: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахим хуудас: manargulx@audit.gov.mn
Аудитор С.Нурлан
Утас: 94209011
Цахим хуудас: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
ягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Table of Contents

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТТОЙ УЯЛДСАН БАЙНА.....	8
A.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байна	8
A.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна	8
A.1.2. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой судалгаанд үндэслэн гаргасан байна	9
A.1.3. Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан байна	12
A.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг ХЭДДС-гаас төлөвлөж, хуваарилж ирсэн байна	12
A.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг аймгийн ХХҮГ-аас хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулж баталсан байна	12
A.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн 77.2 хувийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна	15
A.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг төлөвлөж, хуваарилсан байна	16
A.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоотой ажилласан байна	17
A.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд хамтран ажилласан байна	17
A.3.2. Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 2018-2019 онд 200.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна	18
A.3.3. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн зарим чиг үүрэг хэрэгжээгүй байна	19
A.3.4. Бодлогын хэрэгжилтэд холбогдох байгууллагуудаас хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна	21
БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД 14391 АЖЛЫН БАЙР БИЙ БОЛСОН БАЙНА.....	23
B.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна	23
B.1.1. Аймгийн хэмжээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна	23
B.1.2. Хөдөлмөрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг зохих журмын дагуу ашиглаж, мэдээ тайланг гаргаж ажилласан байна	26

Б.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна	27
Б.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд зохих үр дүнгээ өгсөн байна	28
Б.2.1. Гадаад, дотоодын зээл, тусламж, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна	28
Б.2.2. ЖДҮС-аас шалгарсан төсөл, хөтөлбөрийн талаар шилэн дансанд ил тод мэдээлээгүй байна	28
Б.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 38.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна	32
Б.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан байна.....	33
Б.3.1. ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлсэн байна	33
Б.3.2. ХЭДС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тооцсон байна	34
Б.4. МСҮТ-ийн төгсөгчдийн 47.1 хувь нь ажлын байраар хангагдсан байна	36
Б.4.1. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 2019-2021 онд 83.2 сая төгрөгийн тэтгэлэгийг бүрдэл дутуу баримтаар олгосон байна	36
Б.4.2. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал сүүлийн таван жилд жил бүр буурч батлагдсан байна	38
Б.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна	42
Б.5.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар зарим арга хэмжээг авч ажилласан байна	42
Б.5.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр 4010 даатгуулагчийн 3007.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөлтөөр хассан байна	46
Б.5.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлийг хэрэгжүүлсэн байна.....	46
Б.5.4. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөчлөлтийн статистик тоо мэдээг жил бүр үнэн зөв гаргаж мэдээлсэн байна	48
Холбогдох байгууллагуудын санал:	49
ДҮГНЭЛТ: 52	
ЗӨВЛӨМЖ:.....	53
БӨА-ТАГ ТУШААЛ	54
ХАВСРАЛТУУД	55

Товчилсон үгийн тайлбар

АДЗ	Амьжиргааг дэмжих зөвлөл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОЭХ	Ажил олгогч эздийн холбоо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАОЭНХ	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЭТББ	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХБ	Хөдөлмөрийн бирж
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭХАХМэргэжилтэн	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭДДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЗЗМНС	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ШХА	Шведцарийн хөгжлийн агентлаг

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2016-2021 оны төсвийн төсөл, батлагдсан төсөв	15
Хүснэгт 2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны орлогын эх үүсвэр	17
Хүснэгт 3	2016-2021 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулсны төлбөр төлсөн байдал	22
Хүснэгт 4	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, шинэ ажлын байрны тоо	25
Хүснэгт 5	ажил мэргэжил чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгаа	26
Хүснэгт 6	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээ болон хэсэг, бүлгийн сургалтад хамрагдсан иргэдийн судалгаа	27
Хүснэгт 7	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд ЕБ-ын сургуулийн анхлах ангийн хүүхдийн харагдалтын судалгаа	27
Хүснэгт 8	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгаа	28
Хүснэгт 9	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдалтын судалгаа	30
Хүснэгт 10	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэл	31
Хүснэгт 11	Статистикийн хэлтэс ажилгүй эмэгтэйчүүдийн судалгаа	35
Хүснэгт 12	ХЭДС-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт эмэгтэйчүүдийн хамрагдалт	35
Хүснэгт 13	Аймгийн ХЭДСангийн батлагдсан тасав, гүйцэтгэл	36
Хүснэгт 14	Мэдээллийн нэгдсэн сангаас 2019-2021 онд олгогдсон тэтгэлэгийн судалгаа	39
Хүснэгт 15	МСҮТ-ийн лабораторийн кабинетийн стандарт хангалтын судалгаа	43
Хүснэгт 16	2016-2021 онуудын тоног төхөөрөмжийн хангалт	44
Хүснэгт 17	МСҮТ-өөс 2016-2021 оны хичээлийн 5 жилд 2,5 болон 1 жилийн сургалттай ангиудын төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал	44
Хүснэгт 18	Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	45
График 1	2016-2021 оны ажиллах хүч, ажилгүй иргэдийн тоо	14
График 2	ХЭДДСангаас 2016-2021 онд хуваарилсан төсөв	18
График 3	СХСангаас олгосон зээлийн эзлэх хувь	34
График 4	2016-2021 онд ХҮДадлагын батлагдсан төсөв гүйцэтгэл	40-41
График 5	Нийтийг хамарсан ажилд зарцуулсан хөрөнгө, хамрагдсан хүний тоо	48-49

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүнд бий болсон ажлын байны судалгаа	63
Хавсралт 2	Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ноогдох хэмжээний судалгаа	63-64
Хавсралт 3	Дадлагын танхимын нэг суралцагчид ноогдох хэмжээний судалгаа	64

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан ТАБ-ын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх • Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл хөтөлбөр, зорилт арга хэмжээг хэрэгжүүлэгч хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, бусад холбоглох байгууллагуудын 2016-2020 оны үйл ажиллагааг хамруулж, сангийн үйл ажиллагааны ажлын тайлан, санхүүгийн тайлан, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн болон бусад баримт материалыг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудит хийх заавар аргачлалыг ашиглан баримт материалыг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир удирдаж, аудитын менежер Л.Эрдэнэчулуун чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор М.Наранжаргал, Э.Уянга, Ж.Мөнхбилгүүн, Э.Мөнхмандах нар болон орон нутаг дах төрийн аудитын газрын аудитууд хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг 2019 оны 09 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гүйцэтгэж, орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагуудаас аудитын тайлан, судалгааг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч нэгтгэх бөгөөд аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн дотор Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨРҮҮД НЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТТОЙ УЯЛДСАН БАЙНА

А.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байна

А.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-ын зорилт 2-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тугагдсан “Гэр бүлийг тэтгэх, иргэн бүр эрүүл боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах” гэсэн зорилтуудад уялдуулан аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, баталсан байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөрийг удирдлага болгон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит II хуралдааны 10 дугаар тогтоолоор “Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталж, хөтөлбөрийн 3.6 дахь хэсэгт “хөдөлмөр эрхлэлт, сургалт”-ын хүрээнд 19 ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 13-ны А/928 дугаар захирамжаар “Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг 24 хүний, 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/943 дугаар захирамжаар ажлын хэсэгт зөвлөн туслах багийг 6 хүний бүрэлдхүүнтэй тус тус томилон ажиллуулжээ.

“Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050”, 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн, иргэд иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намууд, төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, аймгийн түвшинд хэрэгжүүлэхэд чиглэсэн, орон нутгийн онцлогийг харгалзан зорилт, арга хэмжээг төлөвлөж боловсруулсан байна

Мөн бодлогын баримт бичгийг боловсруулахад шинэчлэгдэн батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан баримтлах зарчмыг мөрдлөг болгосон байна.

Аймгийн таван жилийн үндсэн чиглэлийн хоёрт “Хүний хөгжлийн бодлого”-ын салбарын хүрээнд нэг үндсэн зорилгыг хэрэгжүүлэхээр 4 зорилтыг дэвшүүлсэн байна. Зорилт 2.3-т “Аймгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, дундаж давхаргын хүрээг тэлж, хүн амын ядуурлын түвшинг бууруулна” гэж заасан ба хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 10 дэд зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

“Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг “Алсын хараа 2050”, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг удирдлага болгон эдгээр бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, хувийн хэвшлийн төлөөллийн саналыг үндэслэн боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хоёрт “Хүний хөгжлийн бодлого”-ын 2.3-т “Нийгмийн халамж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлэг рүү чиглэсэн, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн хүн амын ядуурлын түвшинг бууруулна” гэж заасан ба “Ажилтай иргэн, амжиргаатай өрх” зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 9 хөтөлбөр, 20 дэд хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/51 дүгээр захирамжаар “Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нийгмийн халамж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлэг рүү чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн, хүн амын ядуурлын түвшинг бууруулна” гэсэн зорилгын хүрээнд дэвшүүлсэн 8 зорилтын 20 арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгасан байна.

Мөн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 2 дугаар хуралдааны 15 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний 1.3-т “халамжаас хөдөлмөр эрхлэлт”-д тэмүүлнэ зорилтын хүрээнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, эх үүсвэр, хүрэх түвшинг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

А.1.2. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой судалгаанд үндэслэн гаргасан байна

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төгсөгчдийн ажлын байрны талаарх судалгааг бодитой судалгаанд үндэслэн тооцоолж гаргасан байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/588 тоот захирамжаар томилогдсон 38 хүний бүрэлдэхүүнтэй ажлын баг Баян-Өлгий аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тоон болон чанарын судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Ажлын багт удирдлага, зохион байгуулалтын, мэдээлэл цуглуулж боловсруулах, гүйцэтгэх гэсэн ажлын хэсгүүд ажиллаж, багийн бүрэлдхүүнд аймгийн ЗДТГ, ХХҮГ,

Статистикийн хэлтэс, Өлгий сумын ЗДТГ, сумуудын нийгмийн ажилтнууд, МСҮТ-ийн багш, ажилтнууд, аймгийн ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэл, залуучууд болон ахмадын төлөөллүүд оролцсон байна.

Сумдын Засаг дарга нар, судалгааны багийн гишүүдийг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн зөвлөх, ахлах эксперт болон Увс аймгийн Улаангом Политехникийн коллежийн сургалтын арга зүйч нарыг урьж 2 удаа сургалт зохион байгуулсан байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тоон болон чанарын судалгааг хийхэд аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийг судлан ажиллаж байгаа залуучууд, ажилгүй иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажил олгогчид, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагчдаас боловсруулсан судалгааны маягтын дагуу мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэх баг зохион байгуулсан байна.

Мэдээлэл боловсруулах ажлын хэсэг нь тус аймгийн орон нутгийн онцлогт уялдуулан боловсруулсан судалгаанд 12 сумын 370 ажил олгогч, 742 ажил эрхэлж буй залуучууд, 1159 ажилгүй иргэн, 1242 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 648 малчин, 2210 их, дээд сургуульд сурч буй оюутан, 421 МСҮТ-ийн сурагчийг тус тус хамруулж, Европын холбооны “Техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих төсөл-2”-ын санхүүжилтээр гарын авлага ном болгон хэвлүүлж гаргасан байна.

Уг судалгаагаар дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, ажиллах хүний нөөцийн судалгааг гаргах
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, судалгааны арга зүйг эзэмшсэн, мэргэшсэн баг бэлтгэх
- Төр, хувийн хэвшлийн ажлын байрны эрэлтийг ажил, мэргэжил салбар бүрээр тодорхойлох
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн балансын зөрүүд шинжилгээ, дүгнэлт хийх

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 2021 онд аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн тоог гаргах зорилгоор Өлгий сумын 5466, хөдөөгийн 6 сумын 1800 ажилгүй иргэдийг хамруулан судалгааг хийсэн ба үлдсэн бусад сумуудын ажилгүй иргэдийн судалгааг гаргах ажил хийгдэж байгаа юм байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд хийсэн судалгааны үндсэн дээр зургаан дүгнэлт, арван таван зөвлөмж гарган, ойрын 3 жилд хамгийн эрэлттэй хорин мэргэжлийг тодорхойлсон байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн тоон болон чанарын судалгаа хийж, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн 2018, 2019, 2020 оны судалгааны эрэлт, нийлүүлэлтийн талаарх ном болгон гаргасан нь хөдөлмөрийн байгууллагууд, их, дээд сургуульд элсэгчид болон төгсөгчид, орон нутгийн удирдлага, боловсролын байгууллагууд, МСҮТ, төрийн болон төрийн бус байгууллагын удирдлагын хөдөлмөрийн зах зээлийн гарын авлага болсон байна.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.14-т “Хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний

судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах” гэсэн заалттай нийцсэн ажил болжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн баазыг 2016 оноос эхлэн бүрдүүлж “Гөү-Окей” ХХКомпаниас албан ёсны зөвшөөрөл бүхий AXPLORER 3.52 нэртэй санхүүгийн программыг ашигладаг болсон байна. Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн мэдээллийг программын нэгдсэн баазд жил бүр оруулж, шинэчлэн баяжуулалт хийж мэдээ тайланг боловсруулан ХХҮЕГ-ын “ТАЛСТ” системд улирал, хагас, бүтэн жилээр илгээж баталгаажуулж ажилласан байна.

Аймгийн Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлын тушаалаар Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа хийх ажлын хэсэг байгуулагдаж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг жил бүр хийдэг байна.

Судалгааны үр дүнг үндэслэн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлж дүгнэлт гарган, аймгийн хэмжээнд ойрын 2-3 жилийн хугацаанд хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд, ХХҮГ-т бүртгэлтэй ажилгүй иргэдийн судалгааг судлан шинжилж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн материаллаг бааз, багшлах боловсон хүчний нөөцөд тулгуурлан дараагийн хичээлийн жилд элсэлтээр авах хэрэгцээтэй мэргэжлүүдийг тодорхойлдог байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд холбогдох хууль, журмуудыг мөрдлөг болгон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн урт болон богино хугацааны төлөв байдлыг судалж, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгаанд үндэслэн зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төгсөгчдийн ажлын байрны талаарх судалгааг бодитой судалгаанд үндэслэн гаргасан байна.

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж ирүүлсэн 2016-2021 оны хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдийн судалгаанаас үзэхэд ажилгүй иргэдийн тоо 2016 онд 4066, 2017 онд 6572, 2018 онд 7015, 2019 онд 8228, 2020 онд 6548, 2021 онд 5369 хүн байна.

Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж гаргасан ажилгүйдлийн түвшин 2016 онд 9.3 хувь, 2017 онд 12.4 хувь, 2018 онд 12.6 хувь, 2019 онд 24.2 хувь, 2020 онд 20.9 хувь, 2021 онд 13.8 хувьтай байна.

График №1



Эх сурвалж: аймгийн Статистикийн хэлтсийн судалгаа

А.1.3. Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан байна

“Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт аймгийн бүх хэлтэс, агентлагуудын дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын зарим төлөөлөгч зэрэг бүх салбарын удирдах 24 албан тушаалтнуудыг оролцуулсан байна.

Мөн ажлын хэсэгт зөвлөн туслах зорилготой багийг байгуулж, багийн бүрэлдхүүнд төрийн захиргааны, удирдахуйн ухаан, улс төр судлалын докторууд зэрэг өндөр чадвар бүхий мэргэжлийн хүмүүсийн бүрэлдхүүнийг оролцуулж бүх салбарын оролцоог хангасан байна.

Баян-Өлгий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд оролцогч талуудаас гаргасан санал, зөвлөгөөг тусгасан байна.

А.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг ХЭДДС-гаас төлөвлөж, хуваарилж ирсэн байна

А.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг аймгийн ХХҮГ-аас хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулж баталсан байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүр ХНХЯ-наас баталж улсын төсвөөс санхүүжүүлж ирсэн ба тус аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хуваарилсан санхүүжилт нь төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд хүрэлцэдэггүй байна. Энэ нь жил бүр хүргүүлсэн төсвийн төсөл дутуу батлагдаж ирсэнтэй холбоотой байна.

Сангийн төсвийн төслийг боловсруулахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо, сангийн өмнөх оны гүйцэтгэл зэргийг үндэслэн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж төсвийн саналыг ХХҮЕГ-т хүргүүлж ирсэн байна.

Төсвийн төсөл, батлагдсан төсөв 2016-2021 он

Хүснэгт №1

Үзүүлэлт	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он	
	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хүргүүлсэн төсвийн төсөл	Батлагдсан төсөв
Тайлант онд санхүүжих	859.0	460.4	1,150.0	887.4	1,456.3	1,210.7	1,970.6	1,388.6	1,615.4	758.2	1,568.0	751.4
Зөрүү	(398.6)		(262.6)		(245.6)		(582.0)		(857.2)		(816.6)	

Эх сурвалж: Аймгийн ХЭДС-ийн тайлангаас

ХЭДС-ийн 2016-2021 оны төсвийн төслийг 859.0-1568.0 сая төгрөгийн хооронд боловсруулж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэнээс 398.6-816.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Аймгийн 2010-2021 оны хөгжлийн хөтөлбөрийг удирдлага болгон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит II хуралдааны 10 дугаар тогтоолоор “Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 3.6-дахь хэсэгт “хөдөлмөр эрхлэлт, сургалт”-ын хүрээнд 19 ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч шаардагдах санхүүжилтийг төлөвлөж батлаагүй байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит II хуралдааны 15 дугаар тогтоолоор баталсан “Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.3 дахь хэсэгт “халамжаас хөдөлмөр эрхлэлтэд тэмүүлнэ” гэсэн 9 арга хэмжээний 6-д ХЭДС-аас нийт 3,164.0 сая төгрөгийн, үүнээс 2021 онд 398.0 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 2016-2021 онуудад тусгагдсан зорилтын хэрэгжилт, авсан арга хэмжээг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар баталсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн хуралдаанаар аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны Үндсэн чиглэлийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх тухай 23 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар 14 арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- Аймгийн ИТХ-ын 2018 оны ээлжит 8 дугаар хуралдааны 50 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын тайланд хөдөлмөр эрхлэлт, сургалтын талаар хэрэгжүүлсэн 13 арга хэмжээнд үнэлэлт дүгнэлт өгч 2019 оныг “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарласан.
- Аймгийн ИТХ-ын 2019 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн ээлжит 9 дүгээр хуралдааны 58 дугаар тогтоолоор 2019-2020 онд хэрэгжүүлэх “Залуучуудын ажлын байрыг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийг баталсан.

- Тус дэд хөтөлбөрт 9 арга хэмжээг 253.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан боловч санхүүгийн дэмжлэг олгогдоогүй байна. Тус дэд хөтөлбөрийн хүрээнд Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөлтэй хамтран “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв”-ийг 2019 оны 5 дугаар сард байгуулжээ. Загвар төвийн тоног төхөөрөмж, ширээ хэрэгслийг төслөөс гаргаж, ХЭДСангийн хөрөнгөөр төвийн тохижилт засварыг хийж ашиглалтанд оруулан, гэрээгээр 2-3 залууг ажиллуулан, цалин, хөлсийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн байна.
- Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1-01/1056 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл болон Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хянуулахаар хүргүүлсэн байна.

Үндэсний хөгжлийн газраас 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 01/1507 тоот албан бичгээр Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл, Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгах саналыг хавсралтаар ирүүлсэн байна.

Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдрийн 15 хуралдаанаар “Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-г баталж тогтоол гаргасан байна.

Баян-Өлгий аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хүний хөгжлийн бодлогын нэгдүгээр хэсгийн 1.3-т “Халамжаас хөдөлмөр эрхлэлт”-д тэмүүлэх, “Нийгмийн халамж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлэг рүү чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн, хүн амын ядуурлын түвшнийг бууруулах чиглэлээр хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2021-2024 оны төлөвлөгөөнд тусган баталсан байна. Үүнд:

- ✓ Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон аж ахуйн нэгжид ажлын байр бий болгоход бага хүүтэй зээл олгох
- ✓ Аж ахуй, бичил бизнес болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Ажилгүй иргэдийг малын гаралтай түүхий эд боловсруулах, хүнсний ногоо тариалахад тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэн, нийтийг хамарсан ажлын хүрээнд иргэдийг түр ажлын байраар хангах
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжил олгох түр сургалтад хамруулан ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх
- ✓ Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийг ажиллуулж залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулж гарааны бизнес эрхлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, цахимжуулах арга хэмжээ авах

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны 42 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг “хангалттай” гэж дүгнэсэн байна.

А.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн 77.2 хувийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна

ХЭДС-ийн орлогын эх үүсвэр нь улсын төсвийн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүйн төлбөр, жижиг зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс бүрддэг байна.

Тус аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016-2021 онд нийтдээ 6,480.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Үүнд улсын төсвөөс 5,003.2 сая төгрөгийн санхүүжилт авч, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 1,246.3 сая төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 28.2 сая төгрөг, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж /Дэлхийн банк/-аас 39.4 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 0.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, өмнөх оны өр барагдуулах санхүүжилтэд 163.3 сая төгрөг авсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний орлогын эх үүсвэрийн судалгааг хүснэгтээр нэгтгэн харуулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны орлогын эх үүсвэр

Хүснэгт №2		сая төгрөгөөр						
	2016	2017	2018	2019	2020	2021		
Орлогын эх үүсвэр	Орлого	Орлого	Орлого	Орлого	Орлого	Орлого	Нийт орлого	Орлогын хувь
Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө	462.6	803.6	1,158.5	1,354.0	583.0	641.5	5,003.23	77.2
Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж /Дэлхийн банкны санхүүжилт/					24.1	15.3	39.36	0.6
ХБИ ажиллуулаагүй төлбөрийн орлого	2.4	6.2	0.6	7.3	7.6	4.1	28.22	0.4
Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	32.2	94.9	180.9	289.1	260.4	388.8	1,246.33	19.2
Бусад эх үүсвэр	0.3						0.30	0.0
Өмнөх оны өр барагдуулах		77.5		1.0		84.8	163.30	2.5
Нийт	497.5	982.3	1,340.0	1,651.4	875.1	1,122.4	6,480.7	100.0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 2016-2021 онд 5,456.7 сая төгрөгийн санхүүжилт авахаас гүйцэтгэлээр нийтдээ 5,063.6 сая төгрөгийн санхүүжилт авч 393.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгожээ. Үүнд:


2016 онд 2.0 сая, 2017 онд 42.9 сая, 2018 онд 74.5 сая, 2019 онд 49.6 сая, 2020 онд 170.6 сая, 2021 онд 53.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Аймгийн ХЭДСанд төвлөрсөн нийт орлогын 77.2 хувийг улсын төсвөөс олгосон санхүүжилт, 19.2 хувийг санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт, 2.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого, өмнөх оны өр барагдуулах санхүүжилт, 0.4 хувийг Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”, 0.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого тус тус эзэлж байна.

А.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг төлөвлөж, хуваарилсан байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтэд 2016-2021 онд нийтдээ 5,456.7 сая төгрөг хуваарилсан байна.

График №2



Аймгийн ХЭДСанд 2016-2019 онд 460.3-1,388.5 сая төгрөгийн санхүүжилт хуваарилсан бөгөөд хуваарилсан хөрөнгийн хэмжээ нь жил бүр нэмэгдсэн байна. Харин 2020-2021 онд 758.3-751.5 сая төгрөг болж буурсан нь КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой байна. Орон нутгийн төсвөөс 2016-2021 онд Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд ямар нэгэн хөрөнгө хуваарилаагүй байна.

А.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоотой ажилласан байна

А.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд хамтран ажилласан байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн ЗДТГ, Боловсролын газар, Өлгий сумын ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, МХГ, ГБХЗХГ зэрэг байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байна. Хамтран хэрэгжүүлсэн ажлуудаас нь дурдвал:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажилтан илгээх болон хүлээн авах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2016 онд 2, 2017 онд 5, 2018 онд 25, 2019 онд 11 нийт 43 иргэн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлд хамрагдаж, бүртгэлд хамрагдсан иргэдийн мэдээллийг ХХҮЕГ-т хүргүүлж ажилласан байна
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу ажил олгогч нь нийт ажлын байрныхаа талаарх мэдээллийг оны эхэнд нэг удаа, шинээр бий болсон болон байхгүй болсон ажлын байрны талаарх мэдээллийг улирал тутам, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээллийг тухай бүр энэ хуулийн 20.7-д заасан маягтын дагуу харьяалах хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гаргаж өгч аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгүүдийн эрхлэгч нартай хугацаагүй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.
- Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ хэрхэн зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймгийн төвийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяныг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулжээ.
- Аймгийн Хөдөө, аж ахуйн газартай хамтран малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор малчдын туршлага судлах арга хэмжээг жил болгон зохион байгуулсан байна.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн төгсөгчдийг ажилд зуучлах, ажил, мэргэжлийн зөвлөгөө мэдээлэл өгөх, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр хамтран ажилласан байна.
- Мэргэжлийн хяналтын газартай аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт тавих чиглэлээр хамтран ажилласан байна.

А.3.2. Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 2018-2019 онд 200.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны “Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл батлах тухай” 03, 2019 оны 02 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, удирдамжийг шинэчлэн батлах тухай” А/204 тоот тушаал гарсан байна.


Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн гол зорилго нь бичил бизнес эрхлэгчид орон нутгийнхаа онцлогт нийцүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь хөнгөлөлттэй зээл олгож, ажлын байр бий болгох, тогтвортой орлоготой болгохыг дэмжих зорилготойгоор эргэн төлөгдөх, хүүгүй, барьцаагүй, 36 сарын хугацаатай итгэлийн зээлийн хэлбэрээр санхүүжилтийг олгоход чиглэгдсэн байна.

Тус аймагт орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 2018-2019 онд 200.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2018 онд 3 иргэн, аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийг, 2019 онд 6 иргэн, аж ахуйн нэгжид 100.0 сая төгрөгийг тус тус эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон байна.

Харин 2016-2017 он, 2021 онд Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд хөрөнгө батлагдаагүй байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, сонгон шалгаруулалт зарлах талаар өгсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Аудитын явцад Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөс 2019 онд хэрэгжсэн 1, 2020 онд хэрэгжсэн 5, бүгд 6 төслийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж үзэхэд зарим нь төслийн зориулалтын тоног төхөөрөмж, материал худалдан авсан боловч ковид-19 өвчний цар тахлын хязгаарлалтаас шалтгаалан хил хаагдсантай холбоотой 2020-2021 онд үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадаагүй байна.



Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот зарим төслийн хэрэгжилт: “Махны үйлдвэр”, “Вакум цонх үйлдвэрлэл”, “Зайрмагний цех”, “Үхрийн ферм” төслүүдийн хэрэгжилт байдлыг харуулсан зураг

“Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээний 1.5-д ” дансанд шилжиж орсноос хойш 36 сарын дотор хавсралтад тусгасан “Эргэн төлөлт хийх хуваарь”-ийн дагуу төлж барагдуулахаар харилцан тохиролцов” гэж заасны дагуу гэрээ

байгуулан эргэн төлөлтийн хууваарийг гарган баталгаажуулсан боловч гэрээний биелэлт хангалтгүй байна. Тухайлбал:

- Тус аудитын газраас ХЭДС-гийн үйл ажиллагаанд 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2020 онд 8 иргэн, аж ахуйн нэгжийн 69.4 сая төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар албан шаардлага өгөгдсөнөөс 11.1 сая төгрөгийн зээлийг төлүүлсэн байна.
- Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөр 9 иргэн, аж ахуйн нэгжид 10.0-45.0 сая төгрөгийн хооронд олгосон нийт 200.0 сая төгрөгийн зээлийн 2021 оны жилийн эцсийн байдлаар эргэн төлөлтийн тооцоог шалгаж үзэхэд 123.9 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй байгаа нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/204 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын 3.10 дахь заалтыг зөрчиж байна.

Аймгийн ХХҮГ-аас иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх талаар удаа дараа мэдэгдэх хуудас хүргүүлж, шаардаж ажиллаж байгаа боловч үйл ажиллагаа бүрэн явуулж чадахгүй байгаа нэрийдлээр зээлээ төлөхгүй байгаа, 2018 онд олгосон зээлийн гэрээний хугацаа дууссан хугацаа хэтэрсэн зээлдэгчдийг хуулийн байгууллагад шилжүүлэх шат дараалсан арга хэмжээ авч ажилласан байна.

А.3.3. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн зарим чиг үүрэг хэрэгжээгүй байна

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/634, 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/137, 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/256 дугаар захирамжаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь заалтуудыг мөрдлөг болгон аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тус тус баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 тоот тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг мөрдлөг болгон ажилласан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга, гишүүд нь аймгийн ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөлүүд, нарийн бичгийн дарга нь Хөдөлмөрийн хэлтсийн дарга байхаар дүрэмд заасны дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-д заасан эрх, үүргийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөс орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийг боловсруулах чиглэл, зөвлөмж өгсөний дагуу ХХҮГ-аас 2019 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын чуулганаар баталсан боловч хөрөнгө шийдэгдээгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, МАОЭНХ-ны гүйцэтгэх захирал, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үндэсний зөвлөх нар 2017 онд аймгийн салбар зөвлөлийн хуралд оролцож гурван талт түншлэгч байгууллагууд болох АОЭХ, ҮЭХ, төрийн байгууллагуудын ажлын

уялдаа холбоог сайжруулах, хамтран ажиллах талаар зөвлөгөө өгч, аймгийн Засаг даргатай хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зохион байгуулах арга хэмжээ, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх талаар зөвлөлдөж ажилласан байна.

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлагдсан хөтөлбөрүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлд танилцуулан хөтөлбөрүүдэд хамрагдах сумын хуваарийг орон нутгийн хүн ам, ажилгүйдлийн түвшин зэргийг харгалзан хуваарилж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ.
- Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр хэлэлцсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд түншлэлийн гурван байгууллагын оролцоог хангаж ажилласан байна.
- Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийхэд аймгийн ХХҮГ, МСҮТөв зэрэг байгууллагуудыг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажилласан байна.
- Аймагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн, нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд хүргүүлж ажилласан байна.
- Үндэсний зөвлөлийн ажлын албанаас гаргасан аргачилсан удирдамж, зөвлөмжийг үндэслэн аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан зэргээр эрх, үүргээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус аймагт 2016 онд 8 аж ахуйн нэгжид 233, 2017 онд 7 аж ахуйн нэгжид 150, 2018 онд 7 аж ахуйн нэгжид 150, 2019 онд 9 аж ахуйн нэгжид 173, 2020 онд 8 аж ахуйн нэгжид 57, 2021 онд 9 аж ахуйн нэгжид 201 гадаадын иргэнийг тус тус хөдөлмөр эрхлэх санал авч ажиллуулсан байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллах гэрээ байгуулан орон нутгийн ажилгүй иргэдийг ажлын байран дээр дагалдуулан сургаж түр болон байнгын ажлын байраар ханган ажиллаж, гадаадаас ажиллах хүч авч ажиллуулж байгаа байгууллагуудад газар дээр нь хяналт шалгалт хийж, ажлын тайлан, холбогдох судалгааг ХНХЯаманд хүргүүлж ажилласан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дараах чиг үүрэг хэрэгжээгүй байна. Тухайлбал:

Харин аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолын 2.1.1-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрхэн биелүүлж байгаа талаарх тайлан, мэдээлэл авах, хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас үзэхэд 2016-2021 онд 20-49 ажилтантай 101-108 байгууллага, 50-иас дээш ажилтантай 45-47 аж ахуйн нэгж байна.

ХХҮГ-аас ирүүлсэн судалгаанаас үзэхэд 2016-2021 онд 28 аж ахуйн нэгж нийтдээ 28.2 сая төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулсны төлбөр төлсөн байна.

Үзүүлэлт		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
20-49 ажилтантай		101	102	108	109	108	106
50-иас дээш ажилтантай		45	45	46	47	45	45
ХБИ болон одой хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлого	Байгууллагын тоо	5	8	1	5	6	3
	Мөнгөн дүн /мян.төг/	2373.6	6249.6	600.0	7257.6	7646.9	4088.5

/Эх сурвалж: аймгийн ХХҮГазрын санхүүгийн материалаас/

Дээрх байдлаас үзэхэд Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолын 2.1.6 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж ажиллаагүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүнд үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаагүй тогтоолын 2.2.3, 2.2.4 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

А.3.4. Бодлогын хэрэгжилтэд холбогдох байгууллагуудаас хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6-дахь хэсэгт “хөдөлмөр эрхлэлт, сургалт”-ын хүрээнд 15 зорилтын хүрээнд 21 ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд хөдөлмөр эрхлэлтийн талаар хийгдсэн 15 арга хэмжээг 100 хувь, 5 арга хэмжээг 70 хувь биелэгдсэн, 1 арга хэмжээ үнэлэх боломжгүй гэж дүгнэжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн 2017-2020 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээг 92.5 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

Баян-Өлгий аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.6-дахь хэсэгт “хөдөлмөр эрхлэлт, сургалт”-ын хүрээнд 12 ажлыг хэрэгжүүлэхээр тусгагдсанаас аймгийн Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд 11 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувь биелэгдсэн, нийт дундаж үнэлгээг 93.1 хувиар үнэлсэн байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд 8 зорилтын хүрээнд 20 арга хэмжээний 14 нь 100 хувь, 3 нь 90 хувь, 2 нь 70 хувь, 2 нь 50 хувь нийт дундаж үнэлгээг 91.0 хувиар үнэлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д зааснаар тус Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.0-93.1 хувиар дүгнэж, хөтөлбөрт тусгагдсан бүх салбарын зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнг зорилтод түвшинтэй харьцуулан зөв тайлагнахад анхаарах талаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6-д: “Аймаг, сумын хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлж, ажилгүйдлийг бууруулна” гэсэн зорилтын хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан аймгийн ИТХ-аар батлуулахаар бэлэн болгосон байна.

Аймгийн ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсээс 2016-2021 онд хийсэн хяналт-шинжилгээний үнэлгээний тайлангас үзэхэд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/135 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулдаг сургалтын эрх авсан Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2018 онд, хяналт-үнэлгээ хийсэн.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн батлагдсан төсвийн зарцуулалтад эрсдэлд суурилсан хяналт мониторингийг хийсэн.
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний зүгээс хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн баримттай танилцан, мэргэжилтнүүдэд үйл ажиллагаанд холбогдолтой хууль, журмын заалтад тайлбар өгч, мэдээллээр ханган, албан хаагчдын сар, улирал, хагас, бүтэн жилээр дээд байгууллагад өгөх тайлангийн жагсаалтыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилжилтэд хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дотоод аудит цаг тухайд нь хяналт тавьж хяналтын хуудас хөтлөн, тайлан гаргасан.
- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу сумдад 2017-2020 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнтэй газар дээр нь очиж танилцан хяналт хийж, зөвлөгөө өгч, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, зээлээ төлөхгүй байгаа иргэдтэй уулзаж төлбөр барагдуулах мэдэгдэх хуудас өгч, хууль, журмуудыг танилцуулсан.
- Төсөл хөтөлбөрт ирүүлсэн төслүүдийг ажлын хэсэгт оруулан шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгосон баримтад хяналт шалгалт хийж ажилласан байна.

ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн тайлангаас үзэхэд дарга, мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтод заасан хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байгааг анхаарах шаардлагтай байна.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮНД 14391 АЖЛЫН БАЙР БИЙ БОЛСОН БАЙНА

Б.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна

Б.1.1. Аймгийн хэмжээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ нь аж ахуйн нэгж байгууллагуудаас ажлын байрны захиалга авах, тэдгээрийг бүртгэх, ажил хайгч иргэнийг бүртгэх, ажилд зуучлах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах, сургалт, арга хэмжээ зохион байгуулах, иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах, шинэ ажлын байртай болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг нийгмийн зорилтот бүлэгт, иргэдийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн зохион байгуулдаг байна.

Тус аймагт хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд нийтдээ 13922 иргэн хамрагдаж үүнээс 9629 иргэн ажлын байртай болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдсан 13922 иргэнийг үйлчилгээ тус бүр авч үзвэл ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд 8,358 иргэн, ажилд зуучлах үйлчилгээнд 5,564 иргэн тус тус хамрагдсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлагдсан иргэдийн тоо, шинэ ажлын байрны тоо судалгаа 2016-2021 оны байдлаар:

Хүснэгт №4
Он

Ажил мэргэжлийн чиг
баримжаа олгох, зөвлөх
үйлчилгээ

Ажилд зуучлагдсан
иргэдийн тоо

2016	864	958
2017	1,170	938
2018	1,943	1,057
2019	2,117	1041
2020	773	750
2021	1,491	820
Нийт	8,358	5,564

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын тайлангаас

2016-2021 онуудад нэг жилд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд дунджаар 1393 иргэн хамрагдаж, 927 иргэн ажилд зуучлагдан, шинээр 880 ажлын байр бий болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажлын байртай болсон 14,909 иргэнийг үйлчилгээ тус бүр авч үзвэл:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 8,358 иргэн хамрагдаж, үүнээс 4,086 иргэн ажлын байртай болжээ. Үүнээс ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 3,120 иргэн, ажилд зуучлах үйлчилгээний хүрээнд 653 иргэн, бусад арга хэмжээний хүрээнд 313 иргэн ажлын байртай болсон байна.

- Ажилд зуучлах үйлчилгээнд 6,468 иргэнд ажлын байрыг санал болгож, үүнээс 5,564 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 54 хувь нь байнгын ажлын байртай болжээ.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг их, дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан, төгсөгчид, ажил олоход хүндрэлтэй, ажилгүй, ажил хайгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээ мэдээллээр хангах, зорилго зорилтоо тодорхойлоход туслах, нийгмийн болон хувь хүний харилцаа, хандлага нь зөв боловсон байхад нөлөөлөх, ажилд орох арга зам зэрэг олон талын мэдлэг олгох сургалт явуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаарх ойлголтыг төлөвшүүлэх, мэргэжил сонголтын арга замыг эзэмшүүлэх, мэргэжил сонгоход туслах, мэргэжилд хэрхэн бэлтгэх, мэргэжил сонгоход гаргаж болох алдаа зэрэг сэдвүүдээр сургалт явуулж, чиглүүлэн дэмжлэг үзүүлж ажилласан байна. Үүнд:

Хүснэгт №5			
Зорилтот бүлгийн иргэн	Ганцаарчилсан зөвлөгөө	Бүлгийн сургалт	АМЧБО, ЗӨ үйлчилгээ авсан иргэдийн тоо
Ажил хайгч	2283	1706	3,989
Ажилгүйдэлд өртөж болзошгүй	179	0	179
Ажил олоход хүндрэлтэй иргэн	724	0	724
Ерөнхий боловсролын сургуулийн сурагч	195	2,405	2,600
Их, дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөгч	61	580	641
Ажилтан, албан хаагч	2	0	2
ХБИргэн	186	36	222
Гадаадаас буцан ирсэн иргэн	1	0	1
Нийт тоо	3,631	4,727	8358

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын тайлангаас

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний ажил мэргэжил чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн судалгааг нэгтгэж үзэхэд 2016-2019 онд жил бүр өсөлттэй байгаа нь нийтлэг үйлчилгээнд хамрагдах сонирхолтой иргэдийн тоо их /тус аймагт ажилгүй иргэдийн тоо их, ажлын байрны тоо хязгаарлагдмал/ байгаатай холбоотой байна.

Харин 2020 онд дээрх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо буурсан үзүүлэлтэй байгаа нь Ковид-19 цар тахал гарсантай холбоотой “ажил мэргэжил чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ”-ний хэсэг, бүлгээр зохион байгуулах үйлчилгээг хязгаарласантай холбоотой байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээ болон хэсэг, бүлгийн сургалтад хамрагдсан иргэдийн судалгаа

Хүснэгт №6

Утга	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт
Хэсэг, бүлгийн сургалт	739	705	1,231	1,402	0	650	4,727
Ганцаарчилсан зөвлөгөө	124	465	712	715	773	842	3,631
Зөвлөгөө авсан иргэдийн тоо	864	1170	1943	2117	773	1491	8,358

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан 8,358 иргэний 4,727 нь хэсэг, бүлгийн сургалтад, 3,631 нь ганцаарчилсан зөвлөх үйлчилгээнд тус тус хамрагджээ.

Бүлгийн сургалтад 2016-2021 онд нийт 2,985 оюутан, сурагч хамрагдаж, мэргэжил сонголтын зөвлөгөө авсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, Их, дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөгчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор 46 сургуулийн 2,985 сурагчийг хамруулсан байна.

Хүснэгт №7

Он	Ажил, мэргэжлийг чиг баримжаа олгох үйлчилгээний хүрээнд		Нийт хүний тоо	Сургалт, зөвлөгөө авсан байгууллагын тоо
	ЕБС-ийн сурагч	Их, дээд сургууль, коллеж, МСҮТ төгсөгч		
2016-2021	2,405	580	2,985	46

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах бүлгийн сургалтыг 2016-2021 онд сургалтын удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө гарган, батлуулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх мэргэжилтэн болон сургалт зохион байгуулах эрхтэй сургалтын байгууллагатай гэрээ байгуулан ажилласан байна.

Сургалтын үр дүнгээр ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчид өөрийн авьяас чадвар, сонирхол, хүсэл мөрөөдлийг таньж мэдсэн, хүссэн мэргэжлээ сонгоход гарах бэрхшээлийн талаар мэдээлэлтэй болсон, мэргэжлээ зөв сонгох арга замыг эзэмшсэн, хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэлтэй болсон, мэргэжил сонголтын тестээр ажиллаж сурсан байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд 2016-2021 онд бүртгэлтэй давхардсан тоогоор 393 аж ахуй нэгж байгууллагаас 5,720 ажлын байрны захиалга ирүүлснийг тухай бүрд идэвхтэй ажил хайгч иргэдэд хүргэж, 6,468 иргэнд ажлын байр санал болгож, үүнээс 5,564 ажил хайгч иргэнийг өөрт нь тохирох түр болон байнгын ажлын байранд зуучилсан байна. Нийт зуучлагдсан иргэдийн 54.5 хувь нь байнгын ажлын байртай болсон байна.

Аймгийн ХХҮГ нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тавигдах шаардлага MNS 6620:2016” стандарт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А/161

дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржүүдийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал”-ийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас дүгнэлт гаргуулан, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах стандартын шаардлага хангасан 2018 оны 4 дүгээр сарын 11 өдөр №2018/ТҮ01 гэрчилгээ авч ажилласан байна.

Б.1.2 Хөдөлмөрийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийг зохих журмын дагуу ашиглаж, мэдээ тайланг гаргаж ажилласан байна

Аймгийн Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газар нь “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан” /LMIS/ программыг 2016 оноос ашиглаж ирсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэдээллийн баазыг 2016 оноос эхлэн бүрдүүлж “Гөү-Окей” ХХКомпаниас албан ёсны зөвшөөрөл бүхий AXPLORER 3.52 гэсэн санхүүгийн программтай болсон байна. Программд жил бүр санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн мэдээллийг нэгдсэн баазд оруулж, программд шинэчлэн баяжуулалт хийсэн байна. Мэдээ тайланг программаар боловсруулан ХХҮЕГ-ын “ТАЛСТ” системд улирал, хагас, бүтэн жилээр илгэж баталгаажуулдаг байна.

Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн мэдээллийн системд ажил хайгч иргэн, аж ахуйн байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдсан иргэд, шинэ ажлын байрны мэдээллийг бүртгэж, нэгдсэн бүртгэл мэдээллийн системийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Статистикийн хэлтэст хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн системээр дамжуулан мэдээ, тайланг цаг тухайд нь тогтмол хүргүүлж ажиллажээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд үйлчилгээг сар бүр бүртгэж, иргэдийн мэдээллийг шинэчлэн оруулж ажилласан байна. Үүнд:

Хүснэгт №8							
№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	864	1,170	1,943	2,117	773	1,491
2	Бүртгэлтэй ажилгүй ажил хайгч иргэд	1,381	1,256	1,120	1,325	942	752
3	Ажлын байрны захиалга	1,061	1,031	1,008	1,014	760	846
4	Ажилд зуучлагдан орсон иргэд	958	938	1,057	1,041	750	820
5	Шинээр бий болсон ажлын байр	1,011	833	539	1,017	902	978

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс санаачилж Европын Холбооны санхүүжилтээр Герман улсын GFA группийн хэрэгжүүлж буй “Техник, мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих 2”-төслөөс санхүүжүүлж 2017 онд Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацаа /2018-2021 он/-ны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг хийж, Баян-Өлгий аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг тогтоосон байна.

Судалгааны үр дүнд ойрын 3 жилд хамгийн эрэлттэй гэсэн мэргэжлийн жагсаалтыг гаргасан байна. Үүнд:

- Дуу хөгжмийн багш, хүнсний технологич, арьс ширний технологич, хүнд машин механизмын жолооч, оператор, геофизикч, радио телевизийн засварчин, тоног төхөөрөмжийн засварчин, бүжигчин, дуучин, хөгжимчин, малчин, тогооч, мужаан, худалдагч, газар тариалан, фермер, жимсчин, бетон арматур, засалчимэглэлчин, гагнуурчин

Аймгийн төвийн Өлгий сумын ажилгүй иргэдийн судалгааг бодиттой гаргах зорилгоор 2021 онд ажлын хэсэг байгуулж, удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, сумын Багийн засаг дарга нартай хамтран судалгааны ажлыг 4 сарын хугацаатай зохион байгуулжээ.

Судалгаанд ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил хайж байгаа 5,466 иргэнийг хамруулж ажилгүй иргэдийн мэдээллийн бааз үүсгэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд оруулсан байна.

Судалгааны оролцсон иргэдийг боловсролын байдлаар нь авч үзвэл бага, суурь боловсролтой 979, бүрэн дунд боловсролтой 2,923, тусгай мэргэжлийн дунд боловсролтой 419, дээд боловсролтой 1,145 иргэн байна. Үүнээс мэргэжил олгох түр сургалтад 91 иргэнийг хамруулж, 48 иргэнийг байнгын ажлын байранд оруулсан байна. Мөн Улаанбаатар хот, бусад аймаг, орон нутгийн уул уурхай, бүтээн байгуулалтын ажилд 800 иргэнийг ажилд зуучлан, байнгын болон түр ажлын байраар хангажээ.

Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй ажил, мэргэжлийн жагсаалт гарган, аж ахуйн нэгж байгууллагаас эрэлттэй ажлын байрны судалгаа авч, 2016-2021 онд эрх бүхий сургалтын байгууллагуудаар ажилгүй, ажил хайж байгаа 562 иргэнийг мэргэжлийн түр сургалтад хамруулж, 267 иргэн ажлын байртай болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангах “Оролцоо” төслийг 2021 онд аймагт хэрэгжүүлж 109 залууг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж, дадлагад хийлгэн 45 залуу байнгын ажлын байртай болсон байна.

Б.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцож, тайлагнасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас тус аймагт 2016-2021 онд нийтлэг үйлчилгээний зардалд 131.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 130.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөлмөрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээний жиших зардал, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 23 өдрийн А/179 тушаалын нэгдүгээр хавсралтад заасны дагуу Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ болон ажилд зуучлах үйлчилгээний жишиг зардлыг мөрдөж ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2016-2021 онд нийтдээ 13,922 хүн хамрагдаж 130.7 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №9

Он	Үзүүлэлт	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Нийт
Нийт	Хамрагдсан хүн	8,358	5,564	13,922
	Зарцуулсан хөрөнгө /мянган төгрөг/	72,380.5	58,309.4	130,689.9

Эх сурвалж: Аймгийн ХХҮГ-ын тайлангаас

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хэлтэс 2016-2021 онд батлагдсан төсвийн дагуу ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 8,358 иргэнийг хамруулж 72.4 сая төгрөгийг, ажилд зуучлах үйлчилгээнд 5,564 иргэнийг хамруулаж 58.3 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдсан 8,358 иргэний 4,086 нь ажлын байртай болжээ.

Ажилд зуучлах үйлчилгээнд 6,468 иргэнд ажлын байрыг санал болгосноос 5,564 иргэн ажилд зуучлагдсанаас 37 хувь буюу 2,061 нь эмэгтэйчүүд байна.

Б.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд зохих үр дүнгээ өгсөн байна

Б.2.1. Гадаад, дотоодын зээл, тусламж, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна

Тус аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр ямар нэгэн төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Б.2.2. ЖДҮС-аас шалгарсан төсөл, хөтөлбөрийн талаар шилэн дансанд ил тод мэдээлээгүй байна

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2021 онд авч хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн талаар:

Аймгийн ХХҮГ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн төсөөллийг сум болон бусад холбогдох газруудын саналыг үндэслэн хийж, ХНХЯамд хүргүүлсэн байна. ХНХЯам, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийг хуваарилж, санхүүжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2019 онд 9, 2020 онд 5, 2021 онд 7 төсөл хөтөлбөр хэрэгжиж нийтдээ 5456.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 5063.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Гүйцэтгэлээр батлагдсан төсвийн 2020 онд 77.5 хувийг, бусад онуудад 92.9-99.6 хувийг зарцуулсан дүнтэй байна.

Хүснэгт №10

Үзүүлэлт	сая төгрөг					
	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Хэрэгжсэн төслийн тоо	9	8	9	9	5	7
Батлагдсан төсөв						
<i>/сая төгрөг/</i>	460.3	887.4	1,210.7	1,388.6	758.2	751.4

Төсвийн гүйцэтгэл <i>/сая төгрөг/</i>	458.4	844.5	1,136.2	1,339.0	587.6	697.9
Төсвийн гүйцэтгэлийн хувь	99.6	95.2	93.8	96.4	77.5	92.9
Төсөлд хамрагдсан иргэний тоо	1895	4298	4563	4418	2010	868.0
Эх сурвалж: аймгийн ХХҮГ-аарын санхүүгийн холбогдох материалаас						

Хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд 2016 онд 1895, 2017 онд 4298, 2018 онд 4563, 2019 онд 4418, 2020 онд 2010, 2021 онд 868 нийтдээ 18052 иргэн хамрагдаж, 5140 байнгын, 5962 түр ажлын байр бий болсон байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар олгосон зээлийн талаар:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд 1 аж ахуйн нэгжид 130.0 сая, 2017 онд 1 аж ахуйн нэгжид 200.0 сая, 2018 онд 3 аж ахуйн нэгжид 595.0 сая бүгд 5 аж ахуйн нэгжид 925.0 сая төгрөгийн урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг шууд олгож хэрэгжүүлсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны “Орон нутгийн жижиг, дунд, үйлдвэрийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” А/41 дүгээр тушаалаар орон нутагт хэрэгжүүлэхээр баталгаажсан төслийг тухайн аймгийн арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлэхээр 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг хуваарилсан байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих, журам”-ын 6.2 дахь заалт, ХХААХҮС-ын 2019 оны А/119 тоот тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны А/440 дүгээр захирамжаар аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хорооны бүрэлдэхүүнийг баталж ажиллуулсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлд 2019 онд 89 иргэн аж ахуйн нэгж 5.9 тэрбум төгрөгийн төсөл ирүүлснээс аймгийн төсөл сонгон шалгаруулах хорооноос шалгаруулсан шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар банкны шаардлага хангасан 17 аж ахуйн нэгж, иргэнд 952.8 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.

Үүнээс 489.5 сая төгрөгийг боловсруулах үйлдвэрт, 293.3 сая төгрөгийг барилгын материалын үйлдвэрлэлд, 90.0 сая төгрөгийг эрчимжсэн мал аж ахуйд, 80.0 сая төгрөгийг газар тариалангийн салбарт, 90.0 сая төгрөгийг бусад салбарт хуваарилсан байна.

Орон нутагт 2020 онд 1.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хуваарилсантай холбогдуулан төсөл хүлээн авах зарыг аймгийн орон нутгийн телевиз, радио, сонин, веб сайтаар дамжуулан иргэдэд хүргэсэн байна.

Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороонд 38 аж ахуйн нэгж 3.8 тэрбум төгрөгийн төсөл ирүүлснийг хүлээн авч шаардлага хангасан 1.5 тэрбум төгрөгийн 13 төслийг хэлэлцэж 6 төслийг эхний ээлжинд санхүүжүүлэхээр, 7 төслийг эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжүүлэхээр эрэмбэлж аймгийн Засаг даргын 2020 оны А/726 дугаар захирамжаар баталгаажуулсан байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас төсөл нь шалгарсан 6 аж ахуйн нэгжид 490.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэйгээр олгосон байна. Үүнээс 290.0 сая төгрөгийг аялал жуулчлалын салбарт, 200.0 сая төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хуваарилсан байна.

Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2021 оны А/184 тоот тушаалын хавсралтад дурдсан 11 зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцаж, хяналт мониторинг хийж төслийн хэрэгжилтийг дүгнэж ажилласан боловч үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газраас хяналт, мониторинг хийхэд “Толбот алтайн бүргэд” ХХК нь төслөө хэрэгжүүлээгүй, төсөл хэрэгжүүлэх аялал жуулчны баазаа бусдад зарж, зээлийн санхүүжилтийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдож олгосон зээлийг санд буцаан төвлөрүүлэх талаар албан бичиг ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газраас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр олгосон хөнгөлөлттэй төслийн хэрэгжилт, зээлийн ашиглалтад хяналт шалгалт хийж гарсан зөрчлүүдийг арилгах талаар дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өгсөн чиглэлийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг 2020 оны 12 дугаар сарын 15-наас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны хооронд 2019 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 15 иргэн аж, ахуйн нэгжийн төслийн хэрэгжилт, зээлийн ашиглалтад хяналт шалгалт хийж, шалгалтаар 5 төслийн хэрэгжилт хангалтгүй, 1 төслийн менежментийг сайжруулах шаардлагатай, 9 төслийн хэрэгжилт хэвийн боловч эрчимжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэжээ. Илэрсэн зөрчлийг арилгуулах талаар 5 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлж, бусад аж ахуйн нэгжүүдэд шалгалтын дүнгээр Засаг даргын албан бичгээр хүргүүлж ажилласан байна.

Аудитын явцад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зарим төслийн хэрэгжилтийг сонгон шалгаж үзэхэд “Ахбидай” ХХК, “Акбоар” ХХК, “Досмухан” ХХК, М.Азатхан, “Алтын сапа” ХХК, “Еркин принт” ХХК, “Тэнэгэр алтан” ХХК, “Алтайн оймс” ХХК, “Жасыл алхал” ХХК, “Тасымал микро” ХХК зэрэг иргэн, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн байна. Зарим төсөл хөтөлбөрийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- “Алма трейвэл” ХХК, “Жупар” ХХК, “Мон-алтай” фото зэрэг аж ахуйн нэгжүүд Ковид-19 цар тахалтай холбоотой хил хаагдсаны улмаас туслах бүтээгдэхүүний үнэ өсөж борлуулалт буурсны улмаас үйл ажиллагаагаа түр зогсоосон байна.
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2018 онд арьс шир элдэх, засварлах, үслэг арьс чиглэлээр “Хаганат” ХХК 195.0 сая, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр “Асена” ХХК 200.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг шууд шийдвэрлэн олгосон бөгөөд зээлийн санхүүжилтийн ашиглалт хангалтгүй, зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Зээлийн хэрэгжилтийн талаар тодруулж үзэхэд “Хаганат” ХХК нь 195.0 төгрөгөөс 60.0 сая төгрөгийг гутлын үйлдвэрийн тоног төхөөрөмж авахад зарцуулсан боловч үйл ажиллагаа нь зогссон, “Асена” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Жижиг, дунд үйлдвэрийн газраас шууд шийдвэрлэн зээл олгох тохиолдолд орон нутгийн харьяалах байгууллагаас санал авч, газар дээр нь

судалгаа хийж, тухайн төсөл нь хэрэгжих боломжтой эсэхэд анхаарах шаардлагатай байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд 23 иргэн, аж ахуйн нэгжид 1442.8 сая төгрөгийн зээлийг олгосон боловч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 13.5-д “Төсвийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авсан хувь хүний овог нэр, хулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байшил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ”,

Мөн Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих, журам”-ын 13.5-д “Зээл авсан иргэний овог нэр, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд 23 иргэн, аж ахуйн нэгжид олгосон 1442.8 сая төгрөгийн зээлийн талаарх мэдээллийг ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул зөрчлийг арилгаж ажиллах талаар зөвлөмж өгөгдлөө.

Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн судалгаанд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд зээл авсан 23 иргэн, аж ахуйн нэгжид шинээр 32 ажлын байр шинээр бий болсон байна.

Аудитын явцад Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллийн сангаас дээрх аж ахуйн нэгжүүдийн ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг тулгаж үзэхэд 2016-2021 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан 11 аж ахуйн нэгж 12-24 иргэнийг ажлын байраар хангаж, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн байна.

Сум хөгжүүлэх сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар олгосон зээлийн талаар:


Монгол Улсын Засгийн газраас тус аймгийн 14 сумын Сум хөгжүүлэх санд 2011 онд 1150.0 сая, 2013 онд 2300.0 сая, 2014 онд 475.6 нийтдээ 3925.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Сумуудын Сум хөгжүүлэх сангаас 2016-2021 онд барилгын материалын үйлдвэрлэл, хаалга, цонх, модон эдлэл, талх нарийн боов, хувцас үйлдвэрлэл, газар тариалан, үйлчилгээний салбарт нийт 2909.5 сая төгрөгийн зээлийг 827 төсөлд 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай олгосон байна.

Төслүүдийн үр дүнд 457 шинэ ажлын байр бий болсон байна. Ажлын байраар хангагдсан иргэдийн 68.1 хувь буюу 311 нь эмэгтэйчүүд байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 31 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барих, ан агнуур, 13 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар, 34 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 4 хувийг барилга, 4 хувийг байр орон сууц хоол хүнсний үйлчилгээ, 14 хувийг бусад салбарт хуваарилсан байна.

График №3



Сум хөгжүүлэх сангууд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 997 зээлдэгчээс 3,377.9 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Сумуудын Сум хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл, зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд 2021 онд нэгтгэсний үр дүнд Сум хөгжүүлэх сангуудын дансанд нийтдээ 1184.2 сая төгрөгийн зээлийг буцаан төлүүлж, зээлийн эргэн төлөлт өмнөх оноос 34 хувиар өссөн байна.

Тус Аудитын газраас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019-2020 оны үйл ажиллагаанд 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгосон зээлийг хугацаанд төлөөгүй 441 иргэн, аж ахуйн нэгжийн хугацаа хэтэрсэн 729.3 сая төгрөгийн зээлийг санд эргэн төлүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн ба албан шаардлагын мөрөөр тодорхой ажлууд хэрэгжиж байгаа юм байна.

Б.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 38.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 2016-2020 онуудад хэрэгжээгүй бөгөөд 2021 оноос шинээр хэрэгжиж эхэлсэн байна.

Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлогдсон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд 2021 онд “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-д 2.0 сая төгрөг батлагдаж эмэгтэйчүүд, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих сургалт зохион байгуулжээ.

Сургалтыг жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, худалдаа, залуучууд эмэгтэйчүүдийн техник мэдлэг зохион бүтээх чадварыг дэмжих сургалт семинар зохион байгуулах чиглэлээр байгуулагдсан “Кью Эн Эс” ХХК хариуцсан хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэмжлэгтэйгээр аймгийн ЗДТГазар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран ажил эрхлэлтийг дэмжих, ажилгүй иргэдийг орлоготой болгох зорилгоор казак үндэсний гар урлалын эсгий бүтээгдэхүүнийг хөгжүүлэх сургалтыг 2021 оны 7 дугаар сард зохион байгуулсан байна.

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан судалгаанаас үзэхэд ажилгүй иргэдийн дунджаар 57.1 хувийг, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 47.1 хувийг ажилгүй эмэгтэйчүүд эзэлж байна.

Хүснэгт №11

Үзүүлэлт	2016-2021 оны дундаж		
	Бүгд	Эмэгтэй	хувь
Ажилгүй иргэдийн тоо	6299	3592	57.1
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	1059	494	47.1

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Статистикийн мэдээлэл

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2016-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт эмэгтэйчүүдийн хамрагдалтын эзлэх хувийн жинг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №12

Үзүүлэлт	2016 он		2017 он		2018 он		2019		2020		2021		Нийт	
	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй	Хамрагдсан хүний тоо	Үүнээс эмэгтэй
Хамрагдсан иргэн тоо	1131	323	1521	645	1746	623	1862	840	715	257	1135	447	8110	3135

Эх сурвалж: ХЭДС-гийн 2016-2021 оны тайлангаас

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2016-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд нийт 8110 иргэн хамрагдсанаас 38.6 хувийг буюу 3135 нь эмэгтэйчүүд байгаа нь ажилгүй эмэгтэйчүүдийн тоо их байгааг харуулж байна.

Б.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан байна

Б.3.1. ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлсэн байна

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсөв, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө, гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламжаас тус тус бүрддэг байна.

Тус аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2021 онд төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд нийтдээ 5,456.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 5,003.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дэлгэрэнгүй авч үзвэл 2016 онд 462.6 сая, 2017 онд 803.5 сая, 2018 онд 1,158.5 сая, 2019 онд 1,354.0 сая, 2020 онд 583.0 сая, 2021 онд 641.5 сая төгрөгийн нийтдээ 5,003.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 2016 онд 32.2 сая, 2017 онд 94.9 сая, 2018 онд 180.8 сая, 2019 онд 289.1 сая, 2020 онд 260.3 сая, 2021 онд 388.8 сая бүгд 1,246.3 сая төгрөгийг сангийн дансанд оруулж, ХЭДэмжих дэд сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрөөс 2016 онд 2.4 сая, 2017 онд 6.2 сая, 2018 онд 0.6 сая, 2019 онд 7.3 сая, 2020 онд 7.6 сая, 2021 онд 4.1 сая бүгд 28.2 сая төгрөгийн орлогыг зохих журмын дагуу бүрдүүлж, ХЭДэмжих дэд сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламжаас /Дэлхийн банкнаас үйл ажиллагааны санхүүжилтэд/ 2020 онд 7.5 сая төгрөг, 2021 онд 15.3 сая төгрөг бүгд 22.8 сая төгрөгийн санхүүжилт орж, гүйцэтгэлээр 9.1 сая төгрөгийг зарцуулж 13.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Б.3.2. ХЭДС-гийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тооцсон байна

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016-2021 онд төсөл, хөтөлбөр, арга хэмжээ болон нийтлэг үйлчилгээний зардалд нийтдээ 5,456.7 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 5,063.6 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулжээ.

Хүснэгт №13							сая төгрөгөөр					
Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020		2021	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ХЭДС-ийн зарлагын дүн	460.4	458.4	887.4	844.5	1,210.7	1,136.2	1,388.6	1,339.0	758.2	587.6	751.4	697.9
Нийт /2016-2021 оны төлөвлөгөө, гүйцэтгэл/											5,456.7	5,063.6

Гүйцэтгэлээр 2016 онд 458.4 сая, 2017 онд 844.5 сая, 2018 онд 1,136.2 сая, 2019 онд 1,339.0 сая, 2020 онд 587.6 сая, 2021 онд 697.9 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан байна.

Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд улсын төсвийн орлого бүрдүүлэлт хүндэрсэнээс улсын төсвөөс олгох санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс шалтгаалан хувь хүмүүст өгөх зарим санхүүгийн дэмжлэг, түрээсийн хөнгөлөлтийн 28.4 сая төгрөгийн, ажил байрны дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд гэрээний дагуу олгох 56.5 сая төгрөгийн, бусад ажил үйлчилгээний зардлуудыг жилийн эцэст өглөгөөр харуулж 2021 оны эхний хагас жилд нөхөн санхүүжүүлж барагдуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2016 оны 77.5 сая төгрөгийн өглөгийг 2017 онд барагдуулсан байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд, тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн тус тусын онцлогтой хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 1, 2019 оны 1, 2021 оны 1 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих” хөтөлбөрүүд болон Жижиг зээл олгох арга хэмжээг тус тусын онцлогтойгоор батлан хэрэгжүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2020 онд хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрийн 3 буюу хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд КОВИД-19 цар тахалтай холбоотой санхүүжилт олгогдоогүй байна.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрт 2016-2021 онд нийт 210.9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 1,136 хүнийг хамруулж 328 хүн ажлын байраар хангагдаж, үүнээс 311 байнгын ажлын байр, 17 түр ажлын байртай болсон байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2016-2021 онд нийт 2,147.9 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 4,893 хүнийг хамруулж, 3,455 гаруй иргэн ажлын байраар хангагдаж, үүнээс 635 байнгын ажлын байр, 2,820 түр ажлын байртай болсон байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 2016-2021 онд нийт 240 ахмад хамрагдаж 188.9 сая төгрөг зарцуулж, 240 ажлын байр бий болсны 90 нь байнгын, 150 нь түр ажлын байр байна.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсанаар иргэд бизнесээ эрхлэхтэй холбоотой түүхий эд, материалаа худалдан авах, тоног төхөөрөмжөө шинэчлэх, ажилд шаардлагатай багажаа авах асуудлуудаа шийдвэрлэж чаджээ.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 2016-2021 онд нийт 381.4 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 539 залуучуудыг хамруулж, үүнээс 100 гаруй иргэн буюу 18.5 хувь нь байнгын ажлын байртай болгосон байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ, аж ахуй эрхлэлтийн сургалт, борлуулалтын дэмжлэг, ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийг хэрэгжүүлэн төсөлд хамрагдахаар 214 иргэн бүртгүүлснээс 109 иргэн 14 хоногийн сургалтад хамрагдсан байна. Үүнээс 80 иргэн ажлын байрны дадлага хийж, 45 иргэн байнгын ажлын байртай болжээ. Сургалтад хамрагдсан 109 иргэнд 54.5 сая төгрөгийн, ажлын байрны дадлага хийсэн 80 иргэнд

40.0 сая төгрөгийн тэтгэлгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас олгосон байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2016-2021 онд нийт 906.8 сая төгрөгийг зарцуулж, 786 хүнийг хамруулж, 338 иргэн байнгын ажлын байртай болсон байна. Хөтөлбөрийн хүрээнд малжуулах арга хэмжээ, аж ахуй эрхлэлт, мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага солилцох уулзалт, гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг зохион байгуулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2016-2021 онд нийт 430.9 сая төгрөгийг зарцуулж, 708 иргэнийг хамруулж, үүний 32.6 хувь нь буюу 231 ажлын байр бий болсон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүнд 14391 ажлын байр, Жижиг дунд үйлдвэр дэмжих сан, Сум хөгжүүлэх сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр олгосон зээлийн үр дүнд 489 нийтдээ 14880 ажлын байр бий болсон байна. Үүнээс 8796 байнгын, 5595 түр ажлын байр бий болсон байна. /дэлгэрэнгүй судалгааг хавсралт №.1-ээс үзнэ үү/

Б.4. МСҮТ-ийн төгсөгчдийн 47.1 хувь нь ажлын байраар хангагдсан байна

Б.4.1. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 2019-2021 онд 83.2 сая төгрөгийн тэтгэлэгийг бүрдэл дутуу баримтаар олгосон байна

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас мэргэжлийн боловсролын сургалтын төвийн тогтмол зардал, сурагчийн дотуур байрны нийт зардал, мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг, мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал, үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын 2015 оны 477, 2019 оны 12, 2020 оны 44 тогтоолоор баталсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журамд “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасны дагуу суралцагчид олгох тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ” гэж заажээ.

Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын үнэлгээ, ирцийн мэдээллийг мэргэжлийн боловсрол, сургалтын нэгдсэн цахим системд бүртгэсний дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас суралцагчийн тэтгэлгийн мөнгийг суралцагчийн банкин дахь харилцах дансанд шилжүүлдэг байна.

Мэдээллийн нэгдсэн сангаас 2019-2021 онд олгогдсон тэтгэлэгийн судалгааг хүснэгтээр нэгтгэж харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №14

Он	Нийт суралцагч	Ирц бүртгэсэн	Тэтгэлэг олгох	Тэтгэлэг олгох тооцоо	Олгогдсон тооцоо	Үлдэгдэл тооцоо
----	----------------	---------------	----------------	-----------------------	------------------	-----------------

2019 он	2448	2768	2767	276.7	276.7	-
2020 он	5508	6099	6097	1,219.4	1,219.2	0.2
2021 он	4896	5698	5664	1,132.8	1,128.6	4.2
Дүн	12852	14565	14528	2,628.9	2,624.5	4.4

/Эх сурвалж: www.mergejl.mn мэдээллийн нэгдсэн системээс/

Суралдагчдад 2019-2021 онуудад 12852 удаагийн гүйлгээгээр нийтдээ 2,624.5 сая төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх, суралцагчийн нэрсийн жагсаалт баталсан тушаал, багш нарын ангийн журналыг www.mergejl.mn мэдээллийн нэгдсэн системд бүртгэлтэй тэтгэлэг олгосон суралцагчийн жагсаалттай тулгалт хийж шалгахад тухайн хичээлийн жилийн ангийн багшийн журналд бүртгэгдээгүй цахим бүртгэлийн санд бүртгэгдсэн 26 суралцагчид 11.0 сая төгрөгийн тэтгэлгийг олгосон зөрчил илэрснийг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Тус аудитын газраас Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2019-2020 оны үйл ажиллагаанд 2021 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2019-2020 оны хичээлийн жилд олгосон тэтгэлгийн тооцоог шалгаж 18 сурагчид 22.0 сая төгрөгийн тэтгэлэгийг хууль бус олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож, хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитад хамрагдсан 2019-2021 оны хичээлийн жилд тус төвийн захирал, хичээлийн эрхлэгчээр ажиллаж байсан хүмүүс ажлаас халагдсан, тэтгэвэрт гарсан зэрэг шалтгаанаар хариуцах эзэнгүй тул зөвлөмж өгөгдлөө.

Мөн тэтгэлэг илүү авсан сурагчдын ангийн багш нараас журналын бүртгэлтэй холбоотой тодруулга авахад сургуулийн захиргаанаас багш нарт ангийн журналыг хичээлийн жилийн эхэнд өгдөггүй, хэдэн сараар хугацаа хоцроож өгч байгаагаас журнал хүлээж авсан үед байгаа хүүхдээр бүртгэл хөтөлж байгаагаас дунд нь хэдэн сар сураад гарсан хүүхдүүд журналд бүртгэгдээгүй байна.

Мэдээллийн нэгдсэн системийг 2019 онд шинэчилсэнтэй холбоотой 2019 оноос өмнөх жилүүдийн тэтгэлэг авсан суралцагчдын мэдээллийг шалгах боломжгүй байна. Өмнөх аудитаар 7 ангийн багшийн журналыг ирүүлээгүй байсныг багш нарын бусад холбогдох бүртгэлийг үндэслэн тулгаж баталгаажуулсан. Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ: Үүнд:


- Сурагч элсүүлэх, суралцагчийн нэрсийн жагсаалт баталсан элсэлтийн болон нэмэлт тушаалуудыг мэдээллийн нэгдсэн системийн бүртгэлээс тэтгэмж авсан нэрсийн жагсаалтад тулган шалгахад 72.2 сая төгрөгийн зөрүү гарсан ба холбогдох тушаал шийдвэрүүдийг ирүүлээгүй, ангийн багшийн журналд бүртгэгдээгүй цахим бүртгэлийн санд бүртгэгдсэн 26 суралцагчид 11.0 сая төгрөгийн тэтгэлэгийг олгосон.
- Нийгмийн хамгааллын яамнаас баталсан “журнал хөтлөх заавар”-ыг мөрдөж ажиллаагүй зарим ангийн журнал суралцагчдын дэлгэрэнгүй бүртгэлийг хичээлийн жилийн эхэнд мэргэжлийн багш үнэн, зөв бүртгэнэ, сурагчдын хаягийн бүртгэл, эцэг, эх, асран хамгаалагчийн бүртгэл дутуу хөтөлсөн

зэргээр 83.2 сая төгрөгийн тэтгэлэгийг бүрдэл дутуу баримтаар олгосон зөрчилд зөвлөмж өгөв.

Б.4.2. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардал сүүлийн таван жилд жил бүр буурч батлагдсан байна

Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016-2021 оны хичээл үйлдвэрлэлийн дарлагын зардлын батлагдсан төсвийг судалж үзэхэд 2017 онд өмнөх оноос өсөж, 2018-2021 онуудад жил болгон буурч батлагдсан байна.

График №4



Эх сурвалж: МСҮТ-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус төвийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын батлагдсан төсвийг сүүлийн таван жилийн байдлаар харьцуулж үзэхэд 2018 онд 28.0 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар, 2019 онд 5.0 сая төгрөгөөр буюу 5.9 хувиар, 2020 онд 24.4 сая төгрөгөөр буюу 30.8 хувиар, 2021 онд 3.2 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар өмнөх оноос тус тус буурч батлагдсан байна.

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын хавсралтад “хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчийн мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх, зорилгоор гадаад дотоод сургалтад хамруулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа, хоолны зардал, сургалттай холбогдсон материалыг бэлтгэх, багшийн хөлс, төлөх, сургалтын өөрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ. Мөн бүх шатны боловсролын байгууллагуудын үзүүлэн таниулах материал, хичээлийн ба лабораторийн багаж, бодис худалдан авах, сургуулиудын хичээлийн байранд буюу хичээлийн байрнаас гадагч явж дадлага хийхтэй холбогдсон зардлууд хамрагдана” гэж заасныг үзэхэд тус төвийн хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд батлагдсан төсөв нь дадлага хийж ур чадвар олгоход хангалтгүй түвшинд байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг худалдан авах ажлыг жил бүр захирлын тушаалаар баталсан захирлын дэргэдэх үнэлгээний хороо нь аж ахуйн нэгжид үнийн санал ирүүлэх урилга хүргүүлж, харьцуулалтын аргаар буюу хамгийн бага

үнийн санал ирүүлсэн аж ахуй нэгжийг сонгон шалгаруулан гэрээ байгуулж ажилласан байна.

Сургалт үйлдвэрлэлийн дадлагын байранд дадлагын хичээл явуулах багш, үйлдвэрлэлийн дадлагын хичээл явуулах сургалтын төлөвлөгөө, төсөл, материалын жагсаалт хийж, сургалтын албаны дарга, тэнхимийн эрхлэгч нараар батлуулж, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэх зарлагын падаантай хамт санхүүд өгч захирал, ерөнхий нягтлан бодогч нар хянаж худалдан авах материалын үнийг шилжүүлэн өгч ажилласан байна.

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын байрны талаар: Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, номын сан, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна” гэж заажээ.


Аймгийн МСҮТ нь хичээлийн 1, дадлагын 7 байртай ба аудитын явцад мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх болон мэргэжлийн ур чадвар олгоход нэг суралцагчид ногдох сургалтын онолын танхим болон дадлагын газрын талбайн нэг хүүхдэд ногдох хэмжээ нь стандартыг мөрдөж байгаа эсэхийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ногдох хэмжээ 2018-2019 оны хичээлийн жилд 2.54 метр квадрат, 2019-2022 оны 3 хичээлийн жилд 2.47 метр квадрат байгаа нь Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан MNS 6541:2015 “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага, стандарт”-ын 10.5-ын “А”-д “Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ногдох хэмжээ 2 м.кв-аас багагүй байна” гэж заасныг хангаж ажилласан байна. / хавсралт № 2-оос үзнэ үү/

Мөн MNS 6541:2015 стандартын 10.5-ын “Б”-д “Дадлагын газрын талбайн хэмжээ тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах техник, тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамааран 40 м.кв-аас доошгүй бөгөөд тоног төхөөрөмж хоорондын зай нь хөдөлмөр аюулгүй ажиллагааны шаардлагыг хангах ба том оврын техник, тоног төхөөрөмж шаардагдах дадлагын газрын талбайн хэмжээ 110 м.кв-аас доошгүй байна” гэж заасан, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 20 дадлагын байртай бөгөөд 5 дадлагын байраас бусад нь стандартын шаардлагын хангасан байна. /хавсралт № 3-аас үзнэ үү/

Аймгийн МСҮТөвийн хүлэмж, газар тариалан, нарийн боов, хоол үйлдвэрлэл, оёдол, гоо сайхан зэрэг 5 дадлагын байр нь стандартын шаардлага хангахгүй байгаа ба зориулалтын дадлагын байргүй тул сургуулийн дотуур байрны анги танхимуудыг ашигладаг байна.

Дээрх дадлагын байраар ашиглаж байгаа дотуур байрны барилга нь 1965 онд баригдсан, 2013 онд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн “Хүний ажиллах амьдрах таатай нөхцөл бүрдүүлж, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх” гэсэн заалтыг ноцтой зөрчиж байгаа гэсэн дүгнэлт гарсан байна.



Хүлэмжийн дадлагын байр



Үсчиний дадлагын байр



Оёдлын дадлагын байр



Тогоочийн дадлагын байр



МСҮТ-ийн лабораторийн 2 өрөө нь стандартын шаардлагыг хангасан ба Стандартын 10.5-ын “В”-д “Сургалтад зориулсан лабораторийн талбайн хэмжээ нь тухайн мэргэжлийн онцлог, шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн овор хэмжээнээс хамааран 40 метр кв-аас доошгүй байх бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна” гэж заасныг мөрдөж ажилласан байна.

Хүснэгт №15

№	Танхимын нэр	Өрөөний №	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /М2/
1	Компьютерийн лаборатори	Өрг 03	16	60
2	Компьютерийн лаборатори	д/г	14	60

Нийт

30

120 м2

Эх сурвалж: МСҮТ-ийн сургалтын албанаас

Дадлагын байрны тоног төхөөрөмжийн хүрэлцээг тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо ширхэг, суралцагчийн нэг төхөөрөмж дээрх хугацаа, суралцагчийн тоо зэрэг үзүүлэлтэд үндэслэн тооцоход компьютер, барилга, гагнуур, тогооч, оёдолчин, мужаан, сантехник зэрэг дадлагын байр олон улсын төсөл хөтөлбөр болон дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалтаар сүүлийн үеийн шинэ тоног төхөөрөмжөөр хангагдаж сургалт явуулж байгаа боловч ихэнх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүд ашиглалтын хугацаа дууссан, хуучирч, элэгдсэн байна.

МСҮТ нь 2016-2021 онд 8.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Хөдөлмөр нийгэм хамгааллын яамнаас 46.5 сая, олон улсын болон бусад төслийн байгууллагуудаас 218.4 сая бүгд 264.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

Хүснэгт №16

Үзүүлэлт	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт дүн
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан	0.5	1.5	1.9		4.4		8.3
Хандив тусламжаар ирсэн	108.2	44.1		57.7	16.0	38.9	264.9
Бүгд	108.7	45.6	1.9	57.7	20.4	38.9	273.2

Эх сурвалж: МСҮТ-ийн 2016-2021 оны санхүүгийн тайлангаас

Дадлагын байрууд орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй байгаа нь чадварлаг ажилтан бэлтгэхэд хангалтгүй байгаа тул сургалтын орчныг сайжруулж, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, шаардлагатай багаж хэрэгслээр хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аудитын явцад зөвлөж ажиллаа.

МСҮТ-өөс 2016-2021 оны хичээлийн 5 жилд 2,5 болон 1 жилийн сургалттай ангиудын төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг судалж үзэхэд төгсөгчдийн 40.6-53.1 хувь нь дунджаар 47.1 хувь нь ажлын байраар хангагдсан байна.

Хүснэгт №17

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	Нийт дүн
Төгссөн хүүхдийн тоо /1, 2.5 жил/	427	418	409	392	400	2046
Ажлын байраар хангагдсан	210	222	214	159	158	963
Эзлэх хувь	49.2	53.1	52.3	40.6	39.5	47.1

/Эх сурвалж: МСҮТ-ийн сургалтын албанаас/

Барилгын салбар түлхүү хөгжиж байгаатай холбоотой барилгын мэргэжлээр төгсөж байгаа суралцагчид түлхүү ажлын байр хангагддаг байна. Тус аймагт том үйлдвэр, аж ахуйн нэгж байхгүй нөгөө талаар ковид-19 цар тахал өвчин гарч зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нь ажил эрхлэлтийн хувь бага гарахад нөлөөлсөн байна.

Б.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрөөс тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна

Б.5.1. Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар зарим арга хэмжээг авч ажилласан байна

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар Коронавирус халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуйн эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачлагыг дэмжих, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Цар тахлын үед аж ахуйн эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлсэн байна.

Ковид-19 цар тахлын үед төрийн үйлчилгээг тасралтгүй явуулах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн бүх төрлийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэдэд зориулж үйлчилгээ тус бүрээр цахим хэлбэрээр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, ковидын үед хөдөлмөр эрхлэлтийн ажлуудыг тасралтгүй хийж хэрэгжүүлсэн байна.

Тус аймагт цар тахлын үед аж ахуйн эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох, малчдыг малжуулах, борлуулалтын дэмжлэг үзүүлэх, нийтийг хамарсан ажил зохион байгуулах зэрэг 4 хөтөлбөр, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийтдээ 349.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 339.4 сая төгрөгийг зарцуулж 97.0 хувьтай байна.

Хүснэгт №18

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү		Хувь
			Хүн	Төсөв	Хүн	Төсөв	Хүн	Төсөв	
3.2.1	Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох эргэн төлөлттэй	30	150.0	44	150.0	14	-	100.0
		Аж ахуй эрхлэлтийн сургалт	10	3.0	44	1.3	34	(1.7)	43.3
		Ажил олгогчид олгох дэмжлэг	6	40.3	8	40.3	2	-	100.0
3.2.2	Малчдыг малжуулах	Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох	13	65.0	14	63.0	1	(2.0)	96.9
		Мал маллах арга ухааны сургалт, уулзалт зохион байгуулах	33	3.9	22	3.9	-11	-	100.0
3.2.3	Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ			7.5		0.8	0	(6.7)	10.7
3.2.4	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах		280	80.1	380	80.1	100	-	100.0
ДҮН			372	349.8	512	339.4	140	(10.4)	97.0

Эх сурвалж: аймгийн ХХҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, холбогдох материалаас

Дээрх хүснэгтээс үзэхэд иргэнд эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох, ажил олгогчид олгох дэмжлэг, мал маллах арга ухааны сургалт, уулзалт зохион байгуулах, нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.

Аж ахуй эрхлэлтийн сургалт, малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд 1.7-6.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Хэмнэгдсэн зардлуудыг задалж харуулахад.

- Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан иргэнийг сургалтад хамрагдсан нэг хүнд ногдох зардлын дээд хэмжээгээр тооцож 1.3 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 43.3 хувийг зарцуулж, 1.7 сая төгрөг илүү төлөвлөгдсөн байна.

- Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгоход 63.0 сая төгрөг буюу батлагдсан төсвийн 96.9 хувийг зарцуулж, 2.0 сая төгрөг хэмнэгдсэн нь тогтоолын 5.1.2-т “арга хэмжээнд хамрагдах өрхөд малгүй болон 150 хүртэл толгой малтай бол 5.0 сая төгрөгийн, 150-200 малтай бог малтай бол 4.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авах зориулалтаар зарцуулна” гэсэн заалтад тохироогүй илүү төлөвлөгдсөн
- Иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдхүүнийг борлуулах цэг ба борлуулалтын дэмжлэг үзүүлээгүйтэй холбоотой батлагдсан 6.7 сая төгрөг хэмнэгдсэн байна

Иргэн, аж ахуйн нэгжид олгосон санхүүгийн дэмжлэгийн талаар:



Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/06 дүгээр тушаалаар “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд “иргэнд санхүүгийн дэмжлэг олгох” арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтын 4.1, 4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажлын байр шинээр бий болгох, хадгалах, хамгаалахад чиглэсэн аж ахуй эрхлэх үйл ажиллагааны төсөлд 12 сумын 35-55 насны 44 иргэнд нийт 150.0 сая төгрөгийн барьцаагүй, хүүгүй, 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгож, гэрээ байгуулан ажиллажээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хамтран гаргасан аж ахуй эрхлэлтийн эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтад орсон 2 байгууллагыг сонгож Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 тоот тогтоолын 2 дугаар хавсралтын 4.3.4-д заасны дагуу 2 удаа сургалт зохион байгуулсан байна.

Төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авахаар төсөл ирүүлсэн, төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг үндэслэн Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдэж, хөл хорио тогтоож, сургалтын арга хэмжээнүүдийг танхимд явуулахыг хязгаарласан тул 6 дугаар сард 32 иргэнд “Дарь овооны эзэд” ТББ-тай хамтран онлайн сургалт зохион байгуулжээ.

Мөн 12 дугаар сард “Ирмүүн төгс” ХХК-тай хамтран 12 иргэнд танхимаар мэргэшсэн сургагч багшийн сургалт зохион байгуулсан байна.



Сургалтыг онлайнаар зохион байгуулсан байдал

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэн, ажил идэвхтэй хайж байгаа 8 иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангасан 6 ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх 40.3 сая төгрөгийг гэрээний дагуу олгож, ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулсан байна.

Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнд дэмжлэг үзүүлээгүй байна.

Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний талаар:

2021 онд хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн хурлаар эргэн төлөлтийг графикийн дагуу төлдөг Алтанцөгц, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумуудын малчдыг малжуулах төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Цар тахлын үед аж ахуйн эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд “малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ”-г зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Орон нутгийн радиогоор болон байгууллагын цахим хуудсаар 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс хөтөлбөрийн талаар 21 хоног иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгсөн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хөтөлбөрт 4 сумын 14 малчин өрхийн 22-43 насны 2-оос доошгүй гишүүнтэй бог малд шилжүүлснээр 45-195 малтай малчин өрхийг малжуулахад 4.0-5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтын 5.1, 5.1.1, 5.1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

“Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ”-г зохион байгуулах ажлын хэсэг хүсэлт ирүүлсэн иргэдийг сонгон шалгаруулж, Ковид-19 цар тахал өвчний тархалттай холбоотой малыг 9 дүгээр сард хүлээлгэж өгсөн байна.



Хөтөлбөрийн шаардлагыг хангасан малчин өрхийг сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлтэй хамтран сонгон шалгаруулж Алтанцөгц сумаас 3, Ногооннуур сумаас 4, Улаанхус сумаас 4, Цэнгэл сумаас 4, бүгд 14 малчин өрхөд 63.0 сая төгрөг зарцуулж, малчдын төслийн дагуу 522 толгой мал худалдан авч өгсөн байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийг сумуудын амьжиргаа дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн гэрээ байгуулж, гэрээний эргэн төлөлтийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоож хавсаргасан байна.

Тус аймагт Улаанбаатар хотоос хөдөөд шилжин суурьшиж, мал маллах болон өрхийн гэрээт малчнаар ажилд зуучлах, малжуулах, гэрээт малчинд малжуулах зэрэг арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг олгоогүй байна.

Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 28 байнгын ажлын байр бий болж, 14 өрхийн амьжиргаа дээшилсэн байна.

Аймгийн ХХААГ, МХГ, Бэлчээр ашиглагчдын холбоо зэрэг байгууллагуудын мэргэжилтнүүд, туршлагатай малчдыг оролцуулан малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхөд мал маллах арга ухаан, малын ашиг шимийг боловсруулах туршлага солилцох уулзалт арга хэмжээг 22 иргэнийг хамруулан нэг удаа зохион байгуулсан байна.

“Файнос-ноос” ХХК, “Алтайн-оймс”-ХХК, “Азат” ХХК, “Өлгий-сүү” ХХК зэрэг малын гаралтай түүхий эд, малын ашиг шим, сүү, цагаан идээ боловсруулах үйдвэрүүдэд туршлага судалсан байна.

Мал маллах арга ухааны сургалт, уулзалт зохион байгуулахад 3.9 сая төгрөг зарцуулсан нь тогтоолын хоёрдугаар хавсралтын 5.3.1-д заасан “энэ арга хэмжээний нийт зардал нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэхүү хөтөлбөрийн 5.1-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуваарилсан нийт хөрөнгийн 5 хувиас ихгүй байна” гэсэн заалтыг мөрдөж ажилласан байна.



Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээний талаар:


Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын вэб сайтад иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдхүүний талаар мэдээлэл байршуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн болон бусад дэмжлэг, жижиг зээл авсан иргэдэд бараа, бүтээгдэхүүн борлуулахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үзэсгэлэн, яармаг зохион байгуулжээ. 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах талаар:

Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт, тохижилт хийх, байгаль орчныг хамгаалах, мод тарих, усны даланг цэвэрлэх, засварлах, нийтийн эзэмшлийн зам засах үйл ажиллагааны хүрээнд нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийг сонгон шалгаруулж 2016 онд 374 иргэнд 72.6 сая, 2017 онд 839 иргэнд 158.5 сая, 2018 онд 691 иргэнд 148.3 сая, 2019 онд 585 иргэнд 111.9 сая, 2020 онд 267 иргэнд 66.5 сая, 2021 онд 380 иргэнд 80.1 сая төгрөгийг нийтийг хамарсан ажилд зарцуулсан байна.

График №5



Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн зургаан арга хэмжээнд 280 хүнийг хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 380 хүн хамрагдаж Засгийн газраас цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар хэрэгжүүлж буй бодлогыг хангаж ажилласан байна.

“Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-т нийтдээ 512 иргэн хамрагдаж 338.7 сая төгрөг зарцуулж, байнгын 103, түр 380, бүгд 483 ажлын байр бий болсон байна.

Б.5.2. Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр 4010 даатгуулагчийн 3007.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөлтөөр хассан байна

Аудитаар холбогдох байгууллагуудаас авсан судалгаа материалыг үндэслээд цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажлуудыг үзэхэд дараах байдалтай байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг хэрэгжүүлэх заавар”-ыг үндэслэн 2020 онд 376 аж ахуйн нэгжийн 3818 даатгуулагчийн 2491.9 сая төгрөгийн, 2021 онд 421 аж ахуйн нэгжийн 3110 даатгуулагчийн 517.4 сая төгрөгийн, давхардаагүй тоогоор нийт 422 аж ахуйн нэгжийн 4010 даатгуулагчийн 3007.3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр чөлөөлөлтөөр хассан байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2020 онд 175 иргэнд 187.4 сая төгрөгийн, 2021 онд 199 иргэнд 287.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Тус аймагт 2020 онд 1560 иргэн, 2021 онд 777 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байна. Төсөвт байгууллагуудаас 540, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс 130, хувийн хэвшлийн байгууллагуудаас 300, бусад байгууллагуудаас 1367, бүгд 2337 иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгож, оронд нь ажилгүй иргэдийг нөхөж авсан нь ажилгүйдлийн түвшинг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Б.5.3. Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлийг хэрэгжүүлсэн байна

Ковид-19 цар тахал өвчний нөлөөгөөр төсвийн орлого бүрдүүлэлт хүндэрсэнтэй холбоотой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны төсвийг жилийн турш 4 удаа тодотгож, ХХҮЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын А/186 дугаар тушаалаар 753.1

сая төгрөг болгон өөрчилж баталсан байна. Энэ нь оны эхэнд баталсан төсвөөс 61.5 хувиар буюу 1203.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хөтөлбөрийн санхүүжилт буурсантай холбоотой санхүүгийн дэмжлэг, түрээсийн хөнгөлөлт, ажлын байрны дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэг, бусад ажил үйлчилгээний зардлууд жилийн эцэст өглөгтэй гарсан байна.

Хөл хорио тогтоож, хил хаагдсан, бараа материалын үнэ өссөн зэргээс шалтгаалан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд, ААН-үүдийн хувьд үйл ажиллагаагаа явуулахад хүндрэлүүд гарч цар тахлын үеийн сөрөг нөлөөлөл үүссэн байна.

Тус аймагт хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар ХЭҮЗ-өөс гарсан шийдвэрүүдийг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн зарим ажлуудыг дурьдвал дараах байдалтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс Хөдөлмөр эрхлэлтийн сангаас олгосон эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн хугацааг короновирус цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хүндрэлийг даван туулах зорилгоор 2020 оны 06 сарын 01-ний өдрөөс 12 сарын 01-ний өдрийг хүртлэх 6 сарын хугацаанд хойшлуулах талаар чиглэл ирсэний дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. 2020 онд үр дүнтэй төсөл хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 3 иргэний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан.

- 2018-2020 онд ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан эргэн төлөлт нь хэвийн байгаа 9 иргэний хүсэлтийн дагуу 6 сараар эргэн төлөлтийг гэрээний хугацааг сунгасан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ирсэн чиглэлийн дагуу Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

- 2020 онд ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан боловч санхүүжилт хүрэлцээгүйгээс хүссэн санхүүгийн дэмжлэг олгогдоогүй 3 ахмад настанд 2.0 сая төгрөгийн, 35-аас дээш насны 7 хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 9.0 сая төгрөгийн нэмэлт санхүүгийн дэмжлэг олгосон.
- 2019-2021 онуудад ХЭДС-аас дэмжлэг авсан 14 иргэнд 11, 12 дугаар сарын түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд 4.7 сая төгрөг зарцуулсан.
- 2021 онд ХЭҮЗ-өөс баталсан цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн хүрээнд 380 иргэнийг хамруулан 338.7 сая төгрөг зарцуулж, 416 байнгын болон түр ажлын байр бий болсон байна.

Мөн Ковид-19 цар тахлын үед дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

- Ковид-19 цар тахлын өвчний улмаас хөл хориотой үед хөтөлбөрүүдийг зарласан тул иргэдэд утсаар болон онлайнаар зөвлөгөө өгч, байгууллагын цахим хуудсаар бүртгэл явуулах холбоосоор иргэдийг бүртгэж ажилласан.
- Тус аймагт 2021 оны 06 дугаар сард Ковид-19 цар тахлын тархалт нэмэгдэж, хөл хорио тогтоож, сургалтын арга хэмжээнүүдийг танхимд явуулахыг хязгаарласан тул аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Дарь овооны эзэд” ТББ-тай

хамтран онлайнаар зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдсан 49 иргэнийг хамруулсан байна.

Б.5.4. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтийн статистик тоо мэдээг жил бүр үнэн зөв гаргаж мэдээлсэн байна

Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлтийн мэдээ, статистик тоо мэдээг ажил хайгч иргэний хөдөлгөөний мэдээ, ажлын байранд зуучлагдсан иргэдийн мэдээ, ажилд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар гаргасан мэдээ, ажил хайгч иргэдийг сумдаар харьцуулсан байдлын мэдээ, ажлын байрны захиалгыг байгууллагын хариуцлагын хэлбэрээр харьцуулан мэдээ, шинээр бий болсон ажлын байр зэрэг статистик тоо мэдээллийн судалгааг жил бүр гаргаж, мэдээлж хэвшсэн байна.

Сангийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангах талаар мэргэжилтнүүдэд тухай бүр зөвлөгөө өгч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй гэрээ байгуулан ажилласан байна.

ХХҮГ-аас хугацаа хэтрэлттэй зээлдэгчдэд хууль журмыг танилцуулан эргэн төлөлтийг хугацаанд нь төлөх талаар сануулах, газар дээр нь очиж шаардах, мэдэгдэх хуудас өгөх, гэрээний хугацаа дуусвар болсон үед төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Холбогдох байгууллагуудын санал:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
E-mail: bayan-ulgui@mol.gov.mn
Утас /факс/: (976) 7042-2428

2022.05.04 № 1/218

танай -ны № -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцав.

Тус аудит нь холбогдох хууль журмын дагуу хийгдсэн тул, аудитын тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ГАЛИЯ



00798436



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг

Утас: (976) 7042-2211

2022.05.05 № 115

танай _____ -ны № _____ -т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн Гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцав.

Тус аудит нь холбогдох хууль журмын дагуу хийгдсэн тул, аудитын тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ДАРГА



Б.НУРГУЛАН

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

83120 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2212, E-mail: msut_bu@yahoo.com

2022.05.05 № 71

танай _____-ны № _____-т

**АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР-т**

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журмын хүрээнд Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд суралцсан суралцагчдад олгосон тэтгэлэгийн тооцоо болон байгууллагын 2016-2021 оны сургалтын үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тус аудит нь холбогдох хууль журмын дагуу хийгдсэн тул аудитын тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй байна.

Хүндэтгэсэн:

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Х.НУРКЕН



ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан байна
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг ХЭДДС-гаас төлөвлөж, хуваарилж ирсэн байна
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг аймгийн ХХҮГ-аас хүргүүлсэн төсвийн төслөөс бууруулж баталсан байна
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн 77.2 хувийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна
5. Орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөлд 2018-2019 онд 200.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна
6. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн зарим чиг үүрэг хэрэгжээгүй байна
7. ЖДҮХС зээл авахаар шалгарсан төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг шилэн дансанд ил тод мэдээлээгүй байна
8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд зохих үр дүнгээ өгч, байнгын болон түр ажлын байр нэмэгдсэн байна
9. МСҮТ-ийн төгсөгчдийн 47.1 хувь нь ажлын байраар хангагдсан байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Нургуланд-д:

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгосон зээл болон бусад холбогдох мэдээллийг Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих, журам”-ын 13.5-д заасны дагуу шилэн дансанд ил тод мэдээлж ажиллах

II. Аймгийн МСҮТ-ийн захирал Х.Нуркен-д:

- Мэдээллийн нэгдсэн системийн бүртгэгдэж тэтгэмж авсан сурагчдын нэрсийг элсэлтийн жагсаалт баталсан тушаалтай тухай бүр тулган баталгаажуулж ажиллах, тушаалаар баталгаажаагүй суралцагчийг мэдээллийн нэгдсэн системийн бүртгэхгүй байх
- Ангийн журнал суралцагчдын дэлгэрэнгүй бүртгэл, сурагчдын хаяг, эцэг, эх, асран хамгаалагчийн бүртгэлийг үнэн зөв бүртгэж Нийгмийн хамгааллын яамнаас баталсан “журнал хөтлөх заавар”-ыг мөрдөж ажиллах

БӨА-ТАГ ТУШААЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/08

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/2017 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /А.Галия/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /Х.Манаргүл/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН

D:\bichig hereg\2022\tushaal.doc

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2016-2021 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүнд бий болсон ажлын байны судалгаа

Төсөл, хөтөлбөрийн нэр	2016-2021 он		нийт
	Байнгын /6 сараас дээш/	Түр /6 сараас доош/	
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	635	2820	3455
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	60	184	244
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	100	0	100
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	338	0	338
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	311	17	328
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	231	0	231
Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөл	45	0	45
Ажилд зуучлах үйлчилгээ	2,990	2,574	5,564
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ	4,086	-	4,086
ДҮН	8796	5595	14391

ХАВСРАЛТ 2:

Сургалтын онолын танхимын нэг суралцагчид ноогдох хэмжээний судалгаа

№	Өрөөний дугаар	Талбайн хэмжээ /метр.кв/	Хүүхдийн багтаамжийн тоо	Нэг удаагийн сургалтын багтаамж /хүүхдийн тоо/			
				2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
1	104	33.4	15	15	15	15	15
2	105	48	30	20	20	20	20
3	106	48	30	18	20	20	20
4	107	30	15	16	16	16	16
5	109	40	30	20	18	18	18
6	110	48	30	30	30	30	30
7	204	48	30	18	16	16	16
8	205	48	30	30	30	30	30
9	206	48	30	15	15	15	15
10	207	45	30	15	15	15	15
11	208	48	30	15	15	15	15

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн

12	211	24	20	15	15	15	15
13	Өрг-2	30	15	15	15	15	15
14	ДБ- 1	30	20	16	20	20	20
15	ДБ- 2	48	20	18	20	20	20
16	ДБ- 3	80	20	16	20	20	20
Нийт		780 м2	425	292	300	300	300
Нийт онолын танхимд суралцагчийн тоо							
Нэг суралцагчид ногдох талбай				2.54 м2	2.47 м2	2.47 м3	2.47 м4

ХАВСРАЛТ 3:

Дадлагын танхимын нэг суралцагчид ноогдох хэмжээний судалгаа

№	Дадлагын байрны нэр	Өрөөний дугаар	2016 он		2017 он		2018 он		2019 он		2020 он		2021 он	
			Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)	Хүүхдийн багтаамж	Талбайн хэмжээ /м²/ (Тон.төх суурилуулсан талбайг оруулан тооцсон)
1	БӨМ өрөг угсрагч	БӨМ №1	18	118	18	118	14	118	13	118	18	118	16	118
2	Засал чимэглэл	БӨМ №2	21	118	21	118	18	118	14	118	18	118	15	118
3	Барилгын мужаан	Мужаан № 1	24	140	24	140	18	140	21	140	18	140	15	140
4	Хийн гагнуур	Сан № 3	15	211	15	211	14	211	12	211	13	211	13	211
5	Сантехник дадлага	Сан №2	30	140	30	140	18	140	23	140	19	140	17	140
6	Цахилгаан дадлага	д/г	17	83	17	83	17	83	13	83	20	83	17	83
7	Хүлэмж	д/г	19	30	19	30	19	30	13	30	15	30	16	30
8	Авто засварын дадлага	Авто № 1	29	92	29	92	17	92	20	92	18	92	28	92
9	Тренажорын дадлага	Авто № 2	29	48	29	48	16	48	20	48	18	48	17	48
10	Үсчиний дадлага	Үсчин № 1	15	48	15	48	16	48	28	48	23	48	17	48
11	Нарийн боовны дадлага	№ 1	15	35	15	35	18	35	16	35	16	35	16	35
12	Хоол үйлдвэрлэлийн дадлага	№ 2	27	35	27	35	32	35	33	35	32	35	29	35
13	Хоол үйлдвэрлэлийн дадлага	№ 3	21	80	21	80	32	80	33	80	19	80	14	80
14	Оёдлын дадлага	№ 1	26	52	26	52	24	52	25	52	30	52	29	52
15	Оёдлын дадлага	№ 2	21	38	21	38	24	38	12	38	11	38	29	38
16	Оёдлын дадлага	№3	20	83	20	83	24	83	15	83	15	83	29	83
17	Газар тариалан фермер	Д/байр №1	19	40	19	40	19	40	13	40	15	40	11	40
18	Гоо сайхан	Сим №1	0	30	0	30	0	30	0	30	19	30	16	30
19	Амьдрах ухааны кабинет	д/б № 5	15	80	15	80	15	80	15	80	15	80	15	80
20	Кузов засвар	д/г	0	80	0	80	13	80	25	80	0	80	22	80
Нийт			381	1581	381	1581	368	1581	364	1581	352	1581	381	1581